

Төсөл
Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Эрүүл
мэндийн сайдын 2019 оны ... дугаар сарын-ны
өдрийн дугаар тушаалын хавсралт

ХҮНСНИЙ НОГОО, ЖИМС, ЖИМСГЭНИЙ ТАРИАЛАЛТАД ХӨДӨӨ АЖ АХУЙН ЗОХИСТОЙ ДАДЛЫГ ХЯЛБАРШУУЛАН НЭВТРҮҮЛЭХ ЗААВАР ¹

Нэг. Нийтлэг зүйл

1.1.Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.19, долоодугаар зүйлийн 7.1.1 дэх хэсэгт тус тус заасны дагуу хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл буюу хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад хөдөө аж ахуйн зохистой дадал (Цаашид “ХААЗД” гэх)-ыг заавал нэвтрүүлнэ.

1.2.Хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад хөдөө аж ахуйн зохистой дадлыг нэвтрүүлэхэд энэхүү хялбаршуулсан зааврыг дагаж мөрдөнө.

1.3.Хялбаршуулан нэвтрүүлэх заавар нь хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад нэвтрүүлэх ХААЗД-ын шаардлага болон Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн хорин гуравдугаар зүйлийн 23.1.2 дэх хэсэгт заасны дагуу ХААЗД-ын зааврын тохирлын үнэлгээг хариуцан гүйцэтгэх эрх бүхий байгууллагын үйл ажиллагааны дэс дараалал, зохион байгуулалтын бүтцийг тодорхойлно.

Хоёр. ХААЗД-ын зааврын үндсэн бүтэц

2.1.Хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад ХААЗД-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар (Цаашид “заавар” гэх) нь хүнсний аюулгүй байдлыг хангах дадал, байгаль орчныг хамгаалах дадал, ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн халамжийг сайжруулах дадал, бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадал, нийтлэг дадал гэсэн 5 үндсэн хэсгээс бүрдэнэ.

2.2.Хэсэг тус бүрт тавигдах шаардлагыг "нэн чухал", "чухал", эсхүл "сонгож хэрэглэх" гэж 3 түвшинд ангилна:

2.2.1."Нэн чухал" шаардлагууд –100 хувь биелүүлж, дагаж мөрдөх ёстой. Эдгээрийг дагаж мөрдөөгүйгээс аюулгүй, шаардлага хангасан бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүй болж, улмаар хүнсний аюулгүй байдал алдагдах өндөр эрсдэлтэй.

2.2.2."чухал" шаардлагууд - 90-ээс доошгүй хувиар биелүүлж, зайлшгүй дагаж мөрдөх ёстой.

2.2.3."сонгож хэрэглэх" шаардлагууд – эдгээрийг үйлдвэрлэл, бүтээгдэхүүний төрөлтэй уялдуулан дагаж мөрдөх ба 50-иас доошгүй хувиар биелүүлж, дагаж мөрдөх ёстой.

Гурав. Хүнсний аюулгүй байдлыг хангах дадал (ХАБХД)

3.1.Хүнсний аюулгүй байдлыг хангах дадал нь тариалалт, хураалт, түүний дараах үе шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулахад оршино.

3.2.Хүнсний аюулгүй байдлыг хангах дадал 11 (1.1-1.10) хэсгээс бүрдэнэ.

3.3. Хүнсний аюулгүй байдлыг хангах дадал тус бүрт хамаарах шаардлага, дотоод хяналтын ажилтан эсхүл хөндлөнгийн аудиторын зүгээс хяналт, шалгалтын үр дүнг тооцох хэлбэр, биелэлтийн төлвийг үнэлэх нөхцлийг Хүснэгт1-д үзүүлэв.

¹ MNS 5140-1 - 2011 Зохион байгуулалт, захирамжлалын баримт бичиг. 1-р хэсэг: Баримт бичгийн нэр, төрөл, тодорхойлолт, 5.3.9. Заавар- Хууль тогтоомж, эрх зүйн актыг хэрэгжүүлэх болон байгууллагын тодорхой чиглэлийн үйл ажиллагааны арга хэлбэр, зохион байгуулалт, дэс дарааллыг нарийвчлан заасан баримт бичиг

| № | Шаардлагууд | Үр дүнг тооцох хэлбэр | Биелэлтийн төлөв: Тийм/Үгүй |
|------------------------------------|---|--|-----------------------------|
| 1.1 Талбайн түүх, менежмент | | | |
| 1.1.1 | Өөрийн талбайд эсхүл хөрш зэргэлдээх талбайд хэрэглэсэн химийн бодис нь таримлыг бохирдуулах эрсдэлтэй эсэхийг тодорхойлох зорилгоор талбайн түүхийг шалгаж, үнэлгээ хийх ба холбогдох эрсдлийг баримтжуулна. (чухал) | Талбайн түүхийн дэвтэр | |
| 1.1.2 | Хэрэв ноцтой эрсдэл тогтоогдвол тухайн эрсдлийг бууруулах арга хэмжээ авалгүйгээр хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалахыг хориглоно. (нэн чухал) | Тайлан ба нотлох баримтууд | |
| 1.1.3 | Бүтээгдэхүүн бохирдох эрсдэлтэй тохиолдолд эрсдэлийг бууруулж, залруулах арга хэмжээ авах ба бохирдлыг тогтмол хянах хөтөлбөрийг хэрэгжүүлж, тайлан, шинжилгээний дүнг хадгална (нэн чухал). | Бохирдлыг хянах хөтөлбөр болон хэрэгжилтийн тайлан | |
| 1.2 Суулгац | | | |
| 1.2.1 | Анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч өөрөө үр, тарьц, суулгацыг үйлдвэрлэвэл ашигласан аливаа бордоо ба/эсхүл химийн бодисын талаар бүртгэл хөтөлж, хэрэглэсэн шалтгааныг тэмдэглэнэ. Бүртгэл нь тухайн бордоо ба/эсхүл химийн бодисын худалдааны нэршил, идэвхитэй бодисын нэр, ашигласан он сар өдөр, ажилтны овог нэр, цацаж хэрэглэсэн арга, тун, хэрэглэсэн шалтгааныг агуулсан байна (Чухал) | Үр, тарьц, суулгацыг бордсон, ариутгасан тухай тэмдэглэл | |
| 1.2.2 | Анхан шатны үйлдвэрлэл эрхлэгч нь үрийн чанарыг (хортон шавьж, таримлын өвчин, вирусгүй г.м.) баталгаажуулсан бичиг баримтыг бүрдүүлж, хадгална. Үрийн чанарыг баталгаажуулсан бүртгэл/гэрчилгээ нь сортын нэршил, сортын цэвэршилтийн зэрэг, цувралын дугаар, нийлүүлэгчийн талаарх мэдээллийг агуулсан байна. (Чухал) | Үрийн чанарыг нотолж харуулсан зураг, бичлэг | |
| 1.2.3 | Тарьц, суулгац, үр үржүүлгийн материал нь хортон шавьж, өвчний шинж тэмдэггүй байна. Хүлэмжид үрслүүлэх тохиолдолд чанарын шаардлага хангасан үрсэлгээ, суулгацыг хэрэглэнэ. Мөн үрсэлгээг баталгаажсан үр үржүүлгийн газраас (Тариалан эрхлэлтийг дэмжих сан/тусгай зөвшөөрөл бүхий үр үржүүлгийн газар/ ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн/ итгэмжлэгдсэн үр үржүүлгийн лаборатори) авна. (Чухал) | Зураг, бичлэг, дагалдах баримт бичиг ба гэрчилгээ | |
| 1.2.4 | Зөвхөн “Хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт”-д орж, батлагдсан нэмэлт/пестицид (мөөгөнцрийн эсрэг бэлдмэл, хортон шавьж устгагч, биоцид ба/эсхүл бусад) -ээр үрийг ариутгана. Ариутгалыг батлагдсан технологийн дагуу гүйцэтгэнэ. (Чухал) | Үр ариутгалын тайлан | |

| | | | |
|------------|---|--|--|
| 1.2.5 | Тарьц, суулгацыг өөр аж ахуй, үр үржүүлгийн газраас авсан бол тэдгээрийн нэр, хаяг, нийлүүлсэн огноог тэмдэглэнэ. (Чухал) | Ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн дэвтэр | |
| 1.2.6 | Хүний биед сөрөг нөлөөтэй нь тогтоогдсон таримлыг тарьж, ургуулахыг хориглоно. | Сортын хянан баталгаа | |
| 1.3 | Хувиргасан амьд организм | | |
| 1.3.1 | Хувиргасан амьд организмын тухай Монгол улсын хууль, холбогдох журамд заасны дагуу хувиргасан амьд организм бүхий таримлыг турших, тариалах үйл ажиллагааг явуулна. (Нэн чухал) | Холбогдох хууль, журамд заасан баримт бичгийн бүрдэл, эрсдлийн үнэлгээ | |
| 1.3.2 | Хувиргасан амьд организм бүхий таримлыг тариалах тохиолдолд энэ тухай холбогдох бүх этгээд, хэрэглэгчид мэдээлсэн байна. (Нэн чухал) | Мэдээлэл хүргэсэн тухай баримтууд | |
| 1.3.3 | ХАО-тай бүтээгдэхүүн нь бусад бүтээгдэхүүнтэй холилдохоос урьдчилан сэргийлэх (зэрэгцээ талбайд тариалсан ХАО-гүй тарималтай санамсаргүйгээр холилдох гэх мэт) зорилгоор ХАО-тай бүтээгдэхүүнтэй хэрхэн харьцах талаар төлөвлөгөө боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллана. (Нэн чухал) | Батлагдсан төлөвлөгөө болон түүний хэрэгжилт | |
| 1.3.4 | ХАО-тай бүтээгдэхүүнийг тусад нь хадгалах ба ачилтын үед бусад тарималтай гэнэтийн тохиолдлоор холилдохоос сэргийлсэн байна.(Нэн чухал) | Ачилтын бүртгэл, биет үзлэгийн дүн | |
| 1.4 | Бордоо ба хөрс сайжруулагч нэмэлтүүд (Ургамлын шим тэжээлийн менежмент ба бордоо ашиглах) | | |
| 1.4.1 | Бордоо ба хөрс сайжруулагч нэмэлтүүдийн хими, биологийн эрсдлийг таримал бүрийн хувьд үнэлж, аюул, эрсдлийн талаар бүртгэл, тэмдэглэл хөтөлнө. (Чухал) | Эрсдлийн үнэлгээний баримт бичгүүд | |
| 1.4.2 | Хэрэв томоохон аюул, эрсдлийг тодорхойлж, үнэлсэн бол бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдлийг багасгах арга хэмжээ авна. (Нэн чухал) | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, үр дүн, биет үзлэгийн дүн | |
| 1.4.3 | Бордоо ба хөрс сайжруулагч нэмэлтүүдийг хэрэглэх шийдвэрийг хөрсний шинжилгээний дүн, ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн/ ургамал хамгааллаар мэргэшсэн ажилтан/байгууллага/ тариалан эрхлэлтийг дэмжих сангийн техникийн зөвлөгөө, эсхүл өөрийн туршлагад үндэслэн гаргана. (шаардлагатай) | Ашиглалтын бүртгэл, мэдээ, эрх бүхий байгууллагын зөвлөмж | |
| 1.4.4 | Хүнд металлын бохирдол тарималд хуримтлагдах эрсдэлгүй бордоо ба хөрс сайжруулагч нэмэлтүүдийг сонгон авч, хэрэглэнээ багасгах ынгулд сонгож хэрэглэнэ. (шаардлагатай) | Ашиглалтын бүртгэл, мэдээ | |
| 1.4.5 | Бордоо ба хөрс сайжруулагч нэмэлтүүдийг таримлын өсөлтийн зохистой үед шаардлагатай технологи ажиллагааг баримтлан ашиглана. (шаардлагатай) | Ашиглалтын бүртгэл, мэдээ | |

| | | | |
|---|---|--|--|
| 1.4.6 | Зохих шаардлагын дагуу боловсруулаагүй, бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэл бүхий органик бордоог ашиглаж болохгүй. Хэрэв органик бордоог аж ахуй дээр боловсруулж байгаа бол хэрэглэх арга, эхлэх болон үргэлжлэх хугацааг бүртгэнэ. Хэрэв бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэл бүхий органик бордоог гаднаас худалдаж авсан бол тухайн бордоог үйлдвэрлэх явцад энэхүү эрсдлийг бууруулах технологи ажиллагааг ашигласан тухай нийлүүлэгчийн мэдэгдлийг авсан байна. (Чухал) | Нийлүүлэгчийн мэдэгдэл, шаардлагад нийцсэнийг нотлох баримтууд | |
| 1.4.7 | Хүний ялгадсыг хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалахад ашиглахыг хориглоно. (нэн чухал) | Биет үзлэгийн дүн | |
| 1.4.8 | Бордоо, хөрс сайжруулагч нэмэлтүүд, органик бордоог хадгалах, холих, ачиж, буулгахад зориулагдсан талбайн байршил, байгууламжийн бүтэц, зохион байгуулалт, ашиглалтын нөхцөл нь таримал болон усны эх үүсвэрийг бохирдуулах эрсдэлгүй байна. (чухал) | Биет үзлэгийн дүн | |
| 1.4.9 | Бордоо, хөрс сайжруулагч нэмэлтүүдийн гарал үүсэл, нэршил, хүлээн авсан огноо, тоо хэмжээ, талбайд хэрэглэсэн огноо, таримлын нэр, талбайн хэмжээ, цацаж хэрэглэсэн хэмжээ, аргачлал, цацаж хэрэглэсэн ажилтны овог нэрийг агуулсан ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийг хөтөлнө. (Чухал) | Ул мөрийг мөрдөн тогтоох бүртгэлийн дэвтэр | |
| 1.4.10 | Органик болон органик бус бордоог таримлыг хурааж, хадгалж буй байр агуулахаас өөр газар хадгална. (Чухал) | Биет үзлэгийн дүн | |
| 1.5 Ус (Усжуулалт/ бороожуулалт) | | | |
| 1.5.1 | Усжуулалт / бороожуулалтад ашиглаж буй ус нь бохирдолгүй, “Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900 - 2018” стандартын шаардлагыг хангасан байна. (Чухал) | Лабораторийн шинжилгээний дүн | |
| 1.5.2 | Хими, биологийн бохирдлын эрсдлийг бууруулах зорилгоор усалгаа, химийн бодис найруулах, бүтээгдэхүүн угаах, цэвэрлэх, ариутгал, халдваргүйжүүлэлтэд ашиглаж буй усыг жил бүр шинжилгээнд хамруулж, бүртгэл хөтлөн, баримт бичгийг хадгална. (Шаардлагатай) | Лабораторийн шинжилгээний дүн | |
| 1.5.3 | Усны хими, биологийн бохирдлын эрсдлийг үнэлэх, туршилт, шинжилгээ явуулах давтамж нь усны эх үүсвэрийн нөхцөл байдалтай уялдсан байна. (Нэн чухал) | Лабораторийн шинжилгээний дүн | |
| 1.5.4 | Усны бохирдлын түвшин өндөр гарсан тохиолдолд аюулгүй, шаардлага хангасан, өөр усны эх үүсвэрийг ашиглах эсхүл тухайн усыг ашиглахын өмнө ариутгаж, халдваргүйжүүлнэ. (Чухал) | Биет үзлэгийн дүн, усанд ариутгал, халдваргүйжүүлэлт хийсэн тайлан | |
| 1.5.5 | Хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах, гэдгээрийг хураасны дараа угааж, цэвэрлэхэд хаягдал, саарал усыг хэрэглэхийг хориглоно. Усны | Биет үзлэгийн дүн, усанд ариутгал, | |

| | | | |
|------------|---|--|--|
| | чанар нь холбогдох хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж буй тохиолдолд саарал усыг цэвэршүүлж, ариутган хэрэглэхийг зөвшөөрнө. (Нэн чухал) | халдваргүйжүүл элт хийсэн тайлан | |
| 1.5.6 | Үйлдвэрлэгчийн заавар/гарын авлагад заасны дагуу усалгааны тоног төхөөрөмжийг ашиглана. (Шаардлагатай) | Техник ашиглалтын дэвтэр, засвар үйлчилгээний бүртгэл | |
| 1.5.7 | Фермер нь эмнэлэг, үйлдвэр, ахуйн хог хаягдлын цэг, бусад шаардлага хангахгүй газраар дайрсан усны эх үүсвэр ашиглахгүй байх, энэ эрсдлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. (Чухал) | Байршлыг харуулсан зураг, схем | |
| 1.6 | Химийн бодист тавих шаардлагууд: | | |
| 1.6.1 | Зөвхөн эрх бүхий байгууллагаас баталсан жагсаалтад орсон пестицидийг хэрэглэнэ. (Нэн чухал) | Батлагдсан жагсаалт болон ашиглалтын тайлан, бүртгэл | |
| 1.6.2 | Химийн бодисыг зөвхөн тусгай зөвшөөрөлтэй нийлүүлэгчээс худалдан авсан байна. (чухал) | Худалдан авалтыг нотлох баримтууд | |
| 1.6.3 | Эрх бүхий ургамал хамгааллын мэргэжилтэн/байгууллагаас зөвлөмж аваагүй тохиолдолд хоёр буюу хэд хэдэн химийн бодисыг холихгүй. (Бага) | Хэрэглэх зааврууд | |
| 1.6.4 | Эрх бүхий байгууллагаас санал болгосон тунгаар химийн бодисыг хэрэглэнэ. Илүүдэл бодисыг хэрэглэхгүй (Чухал). | Зөвлөмж, ашиглалтыг нотлох баримтууд | |
| 1.6.5 | Бүтээгдэхүүнийг бохирдуулахгүй байх нөхцлийг бүрдүүлж илүүдэл химийн бодисыг, зайлуулна. (Чухал) | Химийн бодисыг устгасан тухай тайлан | |
| 1.6.6 | Химийн бодисыг хэрэглэх давтамж, хураахаас өмнө хэрэглэх хугацааг бүтээгдэхүүний зааврыг баримтлан тогтооно. (Гол) | Химийн бодисын ашиглалт, ургац хураалтын тайлан | |
| 1.6.7 | Химийн бодис цацах тоног төхөөрөмж нь эвдрэлгүй байх ба үр дүнтэй ажиллах боломжтойг эрх бүхий техникийн ажилтан шалгасны дараа ашиглана. (Гол) | Техник ашиглалт, засвар үйлчилгээний дэвтэр, биет үзлэгийн дүн | |
| 1.6.8 | Тоног төхөөрөмж бүрийг хэрэглэсний дараа сайтар угаана. Бүтээгдэхүүнийг бохирдуулахгүй байх нөхцлийг бүрдүүлж, угаадсыг зайлуулна. (Гол) | Цэвэрлэгээ хийсэн тухай тэмдэглэл | |
| 1.6.9 | Химийн бодисыг гэрэлтүүлэг сайтай, найдвартай, аюулгүй, бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэлгүй, химийн бодис асгарах, алдагдах үед хэрхэх талаар сануулга байршуулсан, яаралтай тусламжийн тоног төхөөрөмжөөр тоноглогдсон байршилд хадгална. (Бага) | Биет үзлэгийн дүн, сануулга, яаралтай тусламжийн тоног төхөөрөмж | |
| 1.6.10 | Шингэн химийн бодисыг нунтаг бодисын дээд талын тавиур дээр хадгалахгүй. (Гол) | Биет үзлэгийн дүн | |

| | | | |
|------------|--|--|--|
| 1.6.11 | Химийн бодисыг анх ирсэн оригнал саванд нь шошгод заасны дагуу хадгална. Хэрэв химийн бодисыг өөр саванд шилжүүлэн хийсэн бол сав нь химийн бодисын нэр, хэрэглэх тун, давтамжийн талаарх мэдээлэл бүхий шошготой байна. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| 1.6.12 | Химийн бодисын хоосон савыг дахин хэрэглэхгүй бөгөөд аюулгүй газарт цуглуулж, байгаль орчин, үйлдвэрлэлийн бохирдлоос сэргийлэн Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд заасны дагуу устгана. (Гол) | Биет үзлэгийн дүн, устгал хийсэн тухай тайлан, мэдээ | |
| 1.6.13 | Хугацаа нь дууссан, муудсан химийн бодисыг байнга шалгаж, устгах хүртэл аюулгүй газарт хадгална. Эдгээрийг Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журамд заасны дагуу устгана. (Гол) | Биет үзлэгийн дүн, устгал хийсэн тухай тайлан, мэдээ | |
| 1.6.14 | Химийн бодисын нийлүүлэгчийн нэр, худалдан авсан огноо, тоо хэмжээ, үйлдвэрлэсэн огноо, дуусах хугацаа, хэрэглээ зэрэг мэдээллийг агуулсан химийн бодисын нийлүүлэлтийн бүртгэлийг хөтөлж, хадгална. (Бага) | Бүртгэлийн дэвтэр, худалдан авсныг нотлох баримтууд | |
| 1.6.15 | Химийн бодисын тухай мэдээлэл, хэрэглэх шалтгаан, хэрэглэсэн огноо, талбайн байршил, тун, арга, гүйцэтгэгчийн нэрийг агуулсан химийн бодисын хэрэглээний бүртгэлийг тариалан бүр хөтөлж, хадгална. (Гол) | Ашиглалтын дэвтэр | |
| 1.6.16 | Агуулахад хадгалж буй химийн бодис тус бүрийн хувьд нэр, худалдан авсан огноо, тоо хэмжээ, дууссан эсхүл устгасан огноог нарийвчлан тогтоосон бүртгэлийг хөтөлнө. (Гол) | Агуулахын бүртгэл | |
| 1.6.17 | Хэрэв зах зээлд борлуулсан буюу экспортолсон бүтээгдэхүүнд агуулагдах химийн бодисын үлдэгдлийн хэмжээ зөвшөөрөгдөх дээд хэмжээнээс (MRL) хэтэрсэн нь тогтоогдвол тухайн бүтээгдэхүүний борлуулалтыг зогсоож, бохирдлын шалтгааныг тогтооно. Зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлж, залруулах арга хэмжээ авах бөгөөд зөрчил, түүнийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүртгэж, тайлагнана. (Гол) | Тохиолдлын бүртгэл, засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан тухай тайлан | |
| 1.6.18 | Шатах, тослох материал зэрэг таримлын бус зориулалттай химийн бодисыг ашиглах, хадгалах, устгахдаа хүнсний аюулгүй байдалд учрах эрсдэлээс зайлсхийх нөхцлийг бүрдүүлсэн байна. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| 1.6.19 | Хэрэв ургамал хамгааллын цогц арга хэмжээ (УХЦАХ)-г хэрэгжүүлж байгаа бол одоо хэрэглэж буй ургамал хамгааллын арга технологийг нарийвчлан судлаж, хортон шавьжийн өсөлтийг хязгаарлах бусад арга хэмжээтэй уялдуулан, химийн бодисыг хамгийн боломжит бага тунгаар хэрэглэнэ. (Гол) | Ургамал хамгааллын цогц арга хэмжээний төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан | |
| 1.7 | Ургац хураах ба хураалтын дараах ажлууд | | |

| | | | |
|-------|---|---|--|
| 1.7.1 | Хураасан ургацыг талбай, эсхүл зоорь, савлах цехийн шалан дээр шууд байршуулж, тавихгүй. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| 1.7.2 | <i>Тоног төхөөрөмж, чингэлэг, сав баглаа боодол</i> | | |
| a. | Бүтээгдэхүүнтэй шууд харьцаж буй тоног төхөөрөмж, сав баглаа боодлын материал нь хүнсний зориулалттай, цэвэрлэхэд хялбар байна. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| b. | Химийн бодис, хог хаягдал, бусад аюултай бодисыг хадгалахад зориулсан савыг сайтар бүртгэж, шошголох ба бүтээгдэхүүнийг зөөвөрлөх, хадгалахад ашиглахгүй. (Гол) | чингэлэг, сав баглаа боодлын шошго | |
| c. | Бүтээгдэхүүний бохирдлыг бууруулах зорилгоор тоног төхөөрөмж, сав баглаа боодлыг тогтмол засч, сэлбэх ба дам бохирдлоос сэргийлэх зорилгоор химийн бодис, бордоо, хөрсний нэмэлтүүдээс тусад нь хадгална. (Гол) | Завсар үйлчилгээний тайлан, биет үзлэгийн дүн | |
| d. | Тоног төхөөрөмж, сав баглаа боодлын бүрэн бүтэн байдал, бохирдлын түвшинг тогтмол шалгаж, шаардлагатай тохиолдолд засвар, цэвэрлэгээ, ариутгалыг хийж, шаардлага хангахгүй бол устгана. (Гол). | биет үзлэгийн дүн | |
| e. | Үйлдвэрлэгч нь жилд нэгээс доошгүй удаа Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд заасны дагуу хэмжих хэрэгслийн нарийвчлал, хэмжлийн хязгаарыг баталгаажуулна. (Гол) | хэмжих хэрэгслийн баталгаажуулалтын хуудас | |
| 1.7.3 | <i>Барилга байгууламж</i> | | |
| a. | Бүтээгдэхүүнийг тарьж, ургуулах, хураах, цэвэрлэх, ангилах, савлах, хадгалахад ашигладаг барилга байгууламж нь бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдлийг хамгийн бага түвшинд байлгахгаар төлөвлөгдөж, баригдсан байна. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| b. | Бүтээгдэхүүний бохирдлоос урьдчилан сэргийлэх зорилгоор түүнийг цэвэрлэх, ангилах, савлах, хадгалах байгууламжаас тос, тосолгооны материал, түлш, бензин, ХАА-н техник, тоног төхөөрөмжийг тусад нь байрлуулж, хадгална. (Бага) | Биет үзлэгийн дүн | |
| c. | Бохирын систем, хатуу хог хаягдлын цэг нь үйлдвэрийн орчин, усны эх үүсвэрийг бохирдуулах эрсдэлгүйгээр төлөвлөгдөж, баригдсан байна. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| d. | Савлах цех эсхүл зоорины гэрэл нь доргилтод гэсвэртэй эсхүл доргилтоос хамгаалсан бат бөх бүрхүүлтэй байна. (Бага) | Биет үзлэгийн дүн | |
| e. | Хэрэв механик бохирдлын эх үүсвэр болж болзошгүй тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг савлах цех, зоорийн хэсэгт хадгалах тохиолдолд эдгээрийг тусгаарлах ба бүтээгдэхүүнийг боловсруулах, савлах үед ашиглаж болохгүй. (Бага) | Механик бохирдлын эх үүсвэрээс тусгаарласан хана, хаалт | |
| 1.7.4 | <i>Цэвэрлэгээ ба ариутгал</i> | | |
| a. | Бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэл бүхий тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, сав баглаа боодлыг годорхойлж, тогтоон, тогтмол цэвэрлэж, ариутгавал зохино. (Бага) | Цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйтгэл хийсэн тухай | |

| | | | |
|-------|---|--|--|
| | | бүртгэлийн дэвтэр, биет үзлэгийн дүн | |
| b. | Бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэл багатай ариутгал, цэвэрлэгээний бодисыг сонгож, хэрэглэнэ. (Бага) | ариутгал, цэвэрлэгээний бодисын жагсаалт | |
| 1.7.5 | <i>Мал амьтан, хортон шавьжийн хяналт</i> | | |
| a. | Гэрийн тэжээвэр амьтан болон таван хошуу малыг тариалангийн талбайд (ялангуяа тариалангийн талбай болон түүний ойр орчмын хэсэг, ангилж савлах цех болон зоорийн хэсэг) оруулж болохгүй. (Бага) | Биет үзлэгийн дүн | |
| b. | Таримлыг ангилж савлах цех болон зоорь, гэдгээрийн эргэн тойронд хортон шавж цугларахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. (Гол) | Хортон шавжтай тэмцэх заавар, хэрэгжилтийн тайлан | |
| c. | Бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдлийг хамгийн бага түвшинд байлгах нөхцлийг бүрдүүлж, хортон шавьжийг устгах өгөөш, хавх, зангыг байршуулж, тогтмол хянана. Өгөөш бүхий хавхны байршлыг тэмдэглэнэ. (Гол) | Биет үзлэгийн дүн ба байршлын бүртгэсэн тэмдэглэл | |
| 1.7.6 | <i>Хувийн ариун цэвэр</i> | | |
| a. | Ажилчид хувийн ариун цэврийг сахих чиглэлээр сургалтад хамрагдсан байх ба энэ тухай бүртгэл хөтөлсөн байна. (Гол) | Сургалтын тайлан бүртгэл | |
| b. | Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх зааврыг боловсруулж, хэвлэн ажилтнуудад тарааж өгсөн байх ба эдгээрийг хүнд харагдахуйц байршилд өлгөж, тогтоосон байна. (Бага) | Хувийн ариун цэвэр, эрүүл ахуйн талаарх зурагт хуудсыг байршуулсан газар | |
| c. | Ажилчдад зориулан бие засах газар, гар угаах угаалтуурыг шаардлагатай газруудад байршуулсан байх ба эдгээр нь эрүүл ахуйн шаардлагыг хангасан, цэвэрхэн байна. (Гол) | Бие засах газар, гар угаах угаалтуурын хүртээмж, төлөв байдал | |
| d. | Бүтээгдэхүүнийг шууд болон шууд бус замаар бохирдуулах эрсдлийг хамгийн бага түвшинд байлгах нөхцлийг бүрдүүлж, бохир усыг зайлуулна. (Гол) | Бохир ус зайлуулах хоолойн байрлал, төлөв байдал | |
| 1.7.7 | <i>Бүтээгдэхүүнтэй харьцах</i> | | |
| a. | Хүнсний зориулалтаар шууд хэрэглэх бүтээгдэхүүнд ашиглаж буй ус нь ундны усны чанарын шаардлагыг хангасан байна. (Гол) | Лабораторийн шинжилгээний дүн | |
| b. | Ургац хураасны дараа тарималд ашигладаг химийн бодис ба түрхлэг нь энэ зааврын химийн бодист тавих шаарлагууд болон эрх бүхий байгууллагаас гаргасан заавар, зөвлөмжийн шаардлагад нийцсэн байна. (Чухал) | Химийн бодисын жагсаалт | |

| | | | |
|-------|--|--|--|
| c. | Импортлогч улсын шаардлагад нийцүүлэн бүтээгдэхүүнд лабораторийн шинжилгээг хийнэ. (Бага) | Лабораторийн шинжилгээний дүн | |
| 1.7.8 | <i>Хадгалалт ба тээвэрлэлт</i> | | |
| a. | Бүтээгдэхүүнийг хими, биологи болон физикийн бохирдлын эх үүсвэр байж болзошгүй бараа материалаас тусад нь хадгалж, тээвэрлэнэ. (Гол) | Тусгаарласан байдал | |
| b. | Бүтээгдэхүүнийг сэрүүн газар хадгалж, хэт олноор давхарлаж хураахаас зайлсхийх хэрэгтэй. Тээвэрлэлтийн явцад жингийн алдагдлыг бууруулахын тулд бүтээгдэхүүнийг хучина. (Бага) | Биет үзлэгийн дүн | |
| c. | Бүтээгдэхүүнийг бохирдуулах эрсдэл өндөртэй хөрсөн дээр бүтээгдэхүүнийг савласан хайрцгийг шууд тавьж, байршуулж, болохгүй. Тавцан ашиглах бол түүний цэвэр эсэх, химийн бодис асгарсан эсэх, гадны биет болон хорхой шавжаар бохирлогдсон эсэхийг нь шалгаж, бүтээгдэхүүн бохирдуулах эрсдэл байвал түүнийг ашиглахгүй. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| d. | Бүтээгдэхүүнийг ачих тээврийн хэрэгсэл нь цэвэрхэн, аливаа гэмтэлгүй байна. Ачилтын өмнө түүний цэвэр эсэх, химийн бодис асгарсан эсэх, гадны биет болон хорхой шавжаар бохирлогдсон эсэхийг нь шалгана. (Гол) | Засвар үйлчилгээ болон цэвэрлэгээ хийсэн тухай бүртгэл | |
| 1.8 | Ул мөрийг мөрдөн тогтоох ба зах зээлээс буцаан ба татан авах | | |
| 1.8.1 | Тариалангийн талбай, бусад үйлдвэрлэлийн хэсгийг нэр эсхүл кадастрын зургийн байршил тогтоох цэгээр тодорхойлж, газрын зураг дээр тэмдэглэнэ. (Гол) | Байршил тогтоох цэгийн тэмдэглэгээ, газрын зураг | |
| 1.8.2 | Савласан бүтээгдэхүүний шошго дээр байгаа нэр болон бусад тэмдэглэгээ нь түүнийг тарьж, ургуулсан талбай, фермер хүртэл ул мөрийг мөшгин тогтоох боломжийг бүрдүүлсэн, тодорхой, ойлгомжтой хэлбэрээр бичиж, тэмдэглэгдсэн байна. (Гол) | Ул мөрийг мөшгин тогтоох бүртгэлийн шошго дээр байгаа нэр, тэмдэглэгээг шалгах | |
| 1.8.3 | Бүтээгдэхүүний ачилт бүрийн хувьд хүргэх газар, ачсан огноог бүртгэж, хадгалсан байна. (Бага) | Бүртгэл | |
| 1.8.4 | Хэрэв үйлдвэрлэгдсэн бүтээгдэхүүн нь бохирдсон буюу бохирдсон байх ноцтой эрсдэл бий гэж тогтоогдвол тэдгээрийг тусгаарлаж, хэрэв тухайн бүтээгдэхүүнийг борлуулсны дараа энэхүү зөрчил илэрвэл хүлээн авагч тал эсхүл хэрэглэгчид энэ тухай нэн даруй мэдэгдэнэ. (Чухал) | Ажил гүйцэтгэх хэвшсэн дараалал (Standard Operating Procedure (SOP)) ба туршилтын үр дүн | |
| 1.8.5 | Бохирдлын шалтгааныг илрүүлж, зөрчлийг дахин давтагдахаас урьдчилан сэргийлж, залруулах арга хэмжээ авах ба зөрчил, түүнийг арилгах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг бүртгэж, тайлагнана. (Гол) | Бохирдлын үндсэн шалтгаанд дүн шинжилгээ хийж, засч залруулах арга хэмжээ авсан | |

| | | | |
|-------|--|---|--|
| | | тухай тайлан, бүртгэл | |
| 1.9 | Сургалт | | |
| 1.9.1 | Тариаланчид болон бусад ажилчдыг ХААЗД-ыг хэвшүүлэх чиглэлээр сургалтад хамруулж, энэ тухай бүртгэл хөтөлж, хадгална. Сургалт нь дараах асуудлыг хамарсан байна: | Сургалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан, оролцогсдын бүртгэл | |
| a. | Эрх бүхий байгууллагаас зөвшөөрч, санал болгосон химийн бодис эсхүл био-пестицидийг тухайн таримлын хувьд сонгох, худалдан авах, хадгалах, хэрэглэх (гол); | Зөвшөөрөгдсөн бодисын жагсаалт, заавар, сургалтын хөтөлбөрийн агуулга, тест, шалгалтын дүн | |
| b. | Өөрийн үйл ажиллагаандаа зохицсон ургамал хамгааллын цогц арга хэмжээг хэрэгжүүлж, органик бус химийн бодис ашиглахаас зайлсхийх (гол); | УХЦАХ-ний хөтөлбөр, сургалтын хөтөлбөрийн агуулга, тест, шалгалтын дүн | |
| c. | Үндэсний болон Кодексын стандарт, хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний баталдаг “Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” эсхүл импортлогч орны стандартад тодорхойлж, тусгасан пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ (MRL), нэмэлт өөрчлөлтийн талаарх мэдээлэл (Бага); | Химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээг тогтоосон тушаал, сургалтын хөтөлбөрийн агуулга, тест, шалгалтын дүн | |
| d. | Химийн бодисын хадгалах хугацааг шалгах, химийн бодисыг зааврын дагуу зөв ашиглах (Бага); | Химийн бодисын шошго, хэрэглэх заавар, сургалтын хөтөлбөрийн агуулга, тест, шалгалтын дүн | |
| e. | Хууль тогтоомж, хэрэглэгч, зах зээлийн шаардлагын дагуу химийн бодисын үлдэгдлийн хэмжээг тодорхойлох лабораторийн шинжилгээг тодорхой давтамжийн дагуу гүйцэтгэх, дээж авах аргачлал, тэдгээрийн ач холбогдлын талаарх мэдээлэл (Гол). | Бүтээгдэхүүнд химийн бодисын үлдэгдлийн хэмжээг тодорхойлох лабораторийн шинжилгээг гүйцэтгэсэн давтамж, тайлан | |
| 1.9.2 | Сургалтын хэрэгцээ шаардлагыг жилд нэг удаа тодорхойлж, дүгнэнэ (гол). | Сургалтын жилийн ажлын тайлан | |
| 1.10 | Тайлан, бүртгэл | | |

| | | | |
|------------------------------------|--|---|--|
| 1.10.1 | ХХААЗД-ын тайлан, бүртгэлийг гурван жилийн хугацаанд хадгална. (Гол) | Тайлан бүртгэлийн биет үзлэг, архив хөтлөлт | |
| 1.10.2 | Хуучин (хугацаа нь дууссан) дүрэм, журмыг устгаж, зөвхөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хувилбаруудыг ашиглана. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| 1.11 | Үйл ажиллагааг дүгнэх | | |
| 1.11.1 | Хүнсний аюулгүй байдал, үндсэн үйл ажиллагаанд жилд нэгээс доошгүй удаа үнэлгээ хийж, учирч болзошгүй шинэ болон шинэ тутам эрсдлийг тодорхойлон, зөрчил, дутагдлыг засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ. (Гол) | Үнэлгээний тайлан | |
| 1.11.2 | Хийсэн үнэлгээ болон зөрчил, дутагдлыг засч залруулах талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан бүртгэлийг хөтөлж, хадгална. (Гол) | Зөрчил, дутагдлыг засч залруулах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлсэн тухай тайлан | |
| Сонгож хэрэглэх шаардлагууд | | | |
| 1.12 | Сургалтад хамрагдсан ажилтан эсхүл эрх бүхий мэргэжилтэн бордоо/шимт бодис (органик эсхүл органик бус) –ыг талбайд цацаж, хэрэглэснийг нотлох баримт бичгийг бэлэн байлгана. (Бага) | Эрх олгосон гэрчилгээ, үнэмлэх | |
| 1.12.1 | Хөрсний шинжилгээ-таримлын хариу урвалын туршилтын дүн ба/эсхүл ургамал хамгааллын эрх бүхий мэргэжлийн эсхүл эрдэм шинжилгээний байгууллагын зөвлөмжид нийцүүлэн тухайн тарималд зориулсан бордоо/шимт бодисын төрөл, тунг хэрэглэснийг нотлох баримт бичгийн бүрдлийг хангаж, бэлэн байлгана. (Бага) | Тарималд хэрэглэсэн бордоо/шимт бодисын төрөл, тунгийн талаарх бүртгэл | |
| 1.12. 2 | Шинжилгээний дүн, зөвлөмж байхгүй тохиолдолд үйлдвэрлэгч өөрийн мэдлэг, ур чадварт үндэслэн бордооны төрөл ба тунг тодорхойлсныг нотлох баримт бичгийн бүрдлийг хангаж, бэлэн байлгана. (Бага) | Бүртгэл, тайлан болон мэдлэгийн түвшинг тогтоох ярилцлагын дүн | |
| 1.12. 3 | Ургамал хамгааллын эрх бүхий мэргэжлийн эсхүл эрдэм шинжилгээний байгууллагаас боловсруулж гаргасан бордоо/шимт бодисын төрөл, тунгийн талаарх зөвлөмж, зааврыг ашиглана.(Гол) | бордоо/шимт бодисын төрөл, тунгийн талаарх мэргэжлийн байгууллагын зөвлөмж, заавар | |
| 1.13 | Бэлчээрийн болон таримлын ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон хүнсний түүхий эд, бүтээгдэхүүн дэх малын эм, бэлдмэл болон пестицидийн үлдэгдлийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ болон түүнийг тодорхойлох шинжилгээний давтамжид үндэслэн тарималд агуулагдах химийн бодисын үлдэгдлийг лабораторийн нөхцөлд | Химийн бодисын ашиглалтын бүртгэл, тайлан, лабораторийн шинжилгээний дүн | |

| | | | |
|--------|--|---|--|
| | (магадлан итгэмжлэгдсэн лабораторид) тодорхойлох замаар тухайн тарималд химийн бодисыг зөв хэрэглэж байгаа эсэхийг баталгаажуулна. (Бага) | | |
| 1.13.1 | Химийн бодис, түүний тун хэмжээг “Хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт, хэрэглэх хэмжээ” жагсаалтад буй эсэхийг нотлох бичиг баримтыг бүрдүүлж, хадгална.(Бага) | Баталсан шийдвэр, хүчин төгөлдөр жагсаалт | |
| 1.13.2 | Ургамлын хамгааллын бодисыг хольж хэрэглэхэд баримтлах заавар, хольцын харьцааг зөв тодорхойлох (шошгон дээрх зааврыг баримтлан) талаар мэдээлэл бэлтгэж, ашигладаг байна. (Бага) | Батлагдсан заавар | |
| 1.13.3 | Ургамал хамгааллын бодисыг хольж хэрэглэхдээ эдийн засгийн хувьд ашигтай, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл нь хамгийн бага байх хувилбарыг тооцсон байна. (Бага) | Батлагдсан зааврын хэрэгжилтийн тайлан | |

Дөрөв. Байгаль орчныг хамгаалах дадал (БОХД)

4.1. Байгаль орчныг хамгаалах дадал нь хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлийн байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг багасгах зорилготой.

4.2. Байгаль орчныг хамгаалах дадал 13 (2.1 - 2.13) хэсгээс бүрдэнэ.

4.3. Байгаль орчныг хамгаалах дадал тус бүрт хамаарах шаардлага, дотоод хяналтын ажилтан эсхүл хөндлөнгийн аудиторын зүгээс хяналт, шалгалтын үр дүнг тооцох хэлбэр, биелэлтийн төлвийг үнэлэх нөхцлийг Хүснэгт2-д үзүүлэв.

Хүснэгт2

| № | Шаардлагууд | Үр дүнг тооцох хэлбэр | Биелэлтийн төлөв: Тийм/Үгүй |
|------------|---|---|-----------------------------|
| 2.1 | Талбайн түүх ба удирдлага | | |
| | Тариалангийн зориулалтаар ашиглах талбай нь эгц налуу газарт байршихгүй. (Гол) | | |
| | Шинээр тариалангийн зориулалтаар ашиглах талбайн хувьд байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээг хийлгэж, талбайн байгаль орчинд хор хөнөөл учруулах эрсдэлийг тодорхойлж, бүртгэл, тайланг бүрдүүлж, хадгална. Эрсдлийн үнэлгээг хийхдээ талбайн ашиглалтын түүх, газар тариалан эрхлэх, таримлыг хураах, цэвэрлэж, ангилах, хадгалах нь талбайн орчимд хэрхэн нөлөөлөх, зэргэлдээ орших талбайгаас шинээр тариалалт хийх талбайд үзүүлэх болзошгүй нөлөөллийг харгалзан үзнэ. Хэрэв хүрээлэн буй орчин ноцтой эрсдэлд орохоор байвал шинэ талбайд газар тариалангийн үйлдвэрлэл, ургац хураалтын дараахь үйл ажиллагааг явуулахгүй байх, эсхүл ашиглахаас өмнө эдгээр болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах арга хэмжээ авна.(Чухал) | Эрсдлийн үнэлгээ болон хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | |
| | Хэт доройтсон хөрсний үржил шимийг нь бууруулахгүйгээр хадгалах, цаашид доройтохоос урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. (Гол) | Хөрсний үржил шимийн талаарх шинжилгээний | |

| | | | |
|-----|---|---|--|
| | | дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | |
| | Талбайд үйл ажиллагаа явуулахдаа Байгаль орчныг хамгаалах тухай хуульд заасан хөрс, ус, агаар, биологийн олон янз байдал, дуу чимээний талаарх хэм хэмжээг баримтлана. (Гол) | Бүртгэл, хэмжилтийн талаарх тайлан | |
| | Тариалангийн талбай, хүрээлэн буй орчин, хөрсний эвдрэл, химийн бодисын агуулах, хольц бэлтгэх талбай, худаг, цөөрөм, ус зайлуулах хоолой, барилга байгууламж, зам зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулж буй газрыг масштаблан харуулсан газрын зурагтай байна. (Гол) | Газрын бүдүүвч зураг, хөрсний зураглал | |
| 2.2 | Үр, суулгац | | |
| | Химийн бодисын хэрэглээг бууруулах зорилгоор өвчин болон хортон шавжид тэсвэртэй таримлын үр, сорт, тарьц, суулгацыг сонгоно. (Бага) | Сонгосон шалтган, нөхцлийг тодорхойлсон байна. | |
| | Таримлын үр, сорт, тарьц, суулгацыг хөрсний төрөл, үржил шимд нийцүүлэн сонгож, химийн гаралтай бордоо, тэжээлт бодисын хэрэглээнээс зайлсхийх хэрэгтэй. (Бага) | Шалтгаан нөхцлийг баримтжуулсан тайлан, биет үзлэг, ярилцлагын дүн, | |
| 2.3 | Хөрс ба хиймэл хөрс (Хөрсний менежмент) | | |
| | Тариалалтын арга технологи нь хөрсний ангилал, төрөлд нийцсэн, байгаль орчинд сөрөг нөлөөгүй байна. (Гол) | Технологийн карт, тариалалтын явцыг харуулсан видео бичлэг | |
| | Сэлгэн тариалах, өнжөөх төлөвлөгөө гаргахдаа хөрсний зураглалыг ашиглана. (Бага) | Хөрсний зураглал, төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан | |
| | Хөрсний бүтцийг муутгахгүйгээр хадгалж, сайжруулах хөрсний нягтаршлаас сэргийлэх дадлыг хэвшүүлж, хөрсний элэгдэл, доройтлоос зайлсхийнэ. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| | Хөрс, хиймэл хөрсийг ариутгахад химийн бодис ашигласан тохиолдолд талбайн байршил, таримлын нэр, бүтээгдэхүүний худалдааны нэр, химийн бодисын нэршил, хэрэглэсэн огноо, тун, хэрэглэсэн арга, ариутгалыг гүйцэтгэсэн ажилтны нэрийг бүртгэж, тэмдэглэнэ. (Чухал) | Баримтжуулса н тайлан | |
| 2.4 | Бордоо ба хөрс сайжруулагч | | |
| | Итгэмжлэгдсэн лабораторийн хөрсний агрохими, агрофизикийн шинжилгээний дүн, ургамал хамгааллын эрдэм шинжилгээний байгууллагын зөвлөмжийн дагуу | бордоо ба хөрс сайжруулагчий г сонгосон | |

| | | | |
|-----|---|---|--|
| | хөрсний үржил шим алдагдах эсхүл доройтох эрсдлийг харгалзан таримлын төрөл, хөрсний төлөв байдалд нийцүүлэн бордоо ба хөрс сайжруулагчийг сонгож, хэрэглэнэ. (Гол) | үндэслэл шалтгаан, ашиглах явцын талаарх баримтжуулсан тайлан | |
| | Органик бордоо, химийн бордоо, хөрс сайжруулагчийг хадгалах, холих, ачиж, буулгах зориулалттай байгууламжийг тариалангийн талбай, үйлдвэрлэлийн хэсэг, усны эх үүсвэрт дам болон шууд бохирдол үүсгэхээргүй байдлаар төлөвлөж, байршуулж, барьж, ашиглана. (Бага) | Биет үзлэгийн дүн | |
| | Бордоо, хөрс сайжруулагчийг цацахад хэрэглэдэг тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, эрх бүхий техникийн ажилтнаар үзлэг, засвар үйлчилгээг жил бүр хийлгэнэ. (Бага) | Завар үйлчилгээ хийсэн тухай бүртгэл | |
| | Бордоо, хөрс сайжруулагчийг хэрэглэхдээ тэдгээрийн нэр, цацсан талбайн байршил, огноо, хэрэглэсэн хэмжээ, тун, арга, гүйцэтгэсэн ажилтны нэрийг нарийвчлан бүртгэнэ. (Гол) | Ашиглалтын бүртгэл, тайлан | |
| 2.5 | Ус | | |
| | Хөрсний чийгшил, таримлын чийгийн хэрэгцээ, усны нөөцийн хэмжээтэй уялдуулан усжуулалтыг явуулна. Усыг ариг гамтай хэрэглэх, усны алдагдлыг багасгах зорилгоор усжуулалтын системийн бүрэн бүтэн байдал, ашиглалтад тогтмол хяналт тавьж ажиллана. (Гол) | Усалгааны хуваарь, Хөрсний чийгийн биет үзлэг | |
| | Ус хуримтлуулах, хадгалах, ашиглахад Монгол улсын Усны тухай хууль тогтоомжийг баримтлах ба усалгаатай тариалангийн талбайн байршил, хэмжээ, усжуулалт хийсэн давтамж, хугацааг бүртгэнэ. (Гол) | Усжуулалтын системийн ашиглалтын тайлан | |
| | Хүрээлэн буй орчинд учрах эрсдлийг бууруулахын тулд саарал эсхүл бохир усыг цэвэршүүлнэ. (Гол) | саарал эсхүл бохир усыг цэвэршүүлсэн тайлан, бүртгэл | |
| | Ус хэрэглэх, ашиглах эрхийг холбогдох байгууллагаас авсан байх ба усыг зохистой ашиглах, саарал, бохир усны хэмжээг багасгах талаар усны менежментийн төлөвлөгөөг боловсруулж, батлан, хэрэгжүүлж ажиллана. (Гол) | усны менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан | |
| 2.6 | Химийн бодис (ургамал хамгааллын бодис болон бусад бүтээгдэхүүн) | | |
| | Фермер эсхүл ажилчид нь химийн бодисыг зохистой хэрэглэх талаар сургалтад хамрагдсан байна. (Гол) | Сургалтын бүртгэл, тайлан, гэрчилгээ | |
| | Ургамлын өвчин, хортон шавжтай тэмцэхдээ байгаль орчин болон ангууч шавжид хамгийн бага сөрөг нөлөө үзүүлэх химийн бодисыг сонгож, ашиглана. (Гол) | Химийн бодисыг сонгосон үндэслэл, ашиглалтын тайлан | |

| | | | |
|-----|--|--|--|
| | Төв, орон нутгийн ургамал хамгааллын мэргэжлийн болон эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан дүгнэлт, зөвлөмжийн дагуу ургамал хамгаалах арга хэмжээг хэрэгжүүлнэ. (Гол) | УХ-х арга хэмжээг хэрэгжүүлэхэд баримтласан зөвлөмж, баталсан байгууллага, албан тушаалтан | |
| | Ургамал хамгааллын цогц арга хэмжээ (УХЦАХ) болон биологийн аргуудыг хэрэглэж, химийн бодисын хэрэглээг бууруулсан байна. (Гол) | УХЦАХ-г хэрэгжүүлсэн тайлан | |
| | Зөвхөн ургамал хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан “Хөдөө аж ахуйд ургамал хамгааллын зориулалтаар ашиглаж болох пестицидийн жагсаалт”-д орсон ургамал хамгааллын бодисыг импортлох, борлуулах тусгай зөвшөөрөл бүхий нийлүүлэгчээс худалдан авсан химийн бодисыг ашиглана. (Гол) | Худалдан авсан тухай баримт, нотолгоо | |
| | Химийн бодисыг ургамал хамгааллын талаархи мэргэжлийн байгууллагын зөвлөмж, бүтээгдэхүүний шошго дахь зааврын дагуу хэрэглэнэ. (Чухал) | Химийн бодисын ашиглалтын тайлан | |
| | хортон шавж, өвчин үүсгэгч дасан зохицохоос зайлсхийж, ургамал хамгааллын арга хэмжээ болон химийн бодисыг сэлгэж, өөрчилнө. (Бага) | | |
| | Химийн бодисыг зааврын дагуу шаардагдах хэмжээгээр хольж, үлдэгдэлгүй ашиглана. (Гол) | | |
| | Тариалангийн талбай, эргэлт-ашиглалтын зурвас, талбайн гадна орчныг бохирдуулалгүйгээр химийн бодисын үлдэгдэл, түүний савны угаадсыг зайлуулна. Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу химийн бодисын хоосон савыг цуглуулан, зориулалтын цэгт устгана. (Гол) | Устгалын тайлан, бүртгэл, биет үзлэгийн дүн | |
| | Хугацаа дууссан, хэрэглэх боломжгүй химийн бодисыг хаяглаж, шошголон, найдвартай газар хадгалж, Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу зориулалтын цэгт устгана. (Чухал) | биет үзлэгийн дүн | |
| | Химийн бодисын нэр, хэрэглэсэн үндэслэл, шалтгаан, хэрэглэсэн хугацаа, талбайн байршил, тун, хэрэглэх арга, гүйцэтгэсэн ажилтны нэр, шаардлагатай бол агуулахад байгаа химийн бодисын нэр, худалдан авсан огноо, тоо хэмжээ, бүрэн хэрэглэсэн эсхүл устгасан зэрэг мэдээллийг нарийвчлан гаргаж, таримал бүрийн хувьд химийн бодисын ашиглалтын бүртгэл хөтөлнө. (Гол) | химийн бодисын ашиглалтын тайлан | |
| | Таримлыг хураах, ангилах, цэвэрлэх, хадгалах явцад ашигласан химийн бодисыг Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журмын дагуу хадгалж, устгана. (Гол) | Биет үзлэгийн дүн | |
| 2.7 | Хог хаягдлын менежмент | | |

| | | | |
|------|--|---|--|
| | Таримлыг тарих, хураах, ангилах, цэвэрлэх, хадгалах явцад үүссэн хог хаягдал, давхиврыг ангилах, хог хаягдлыг багасгах, дахин ашиглах, боловсруулах, устгах зэрэг асуудлыг хамарсан хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг Хог хаягдлын тухай хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж, батлуулан, хэрэгжүүлж, баримтжуулна. (Гол) | хог хаягдлын менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт, биет үзлэгийн дүн | |
| 2.8 | Эрчим хүчний хэмнэлт | | |
| | Цахилгааны болон түлшний хэрэглээг хянаж, үр ашигтай зарцуулах дадлыг хэвшүүлнэ. (Гол) | Ашиглалтын бүртгэл | |
| | Машин механизм, тоног төхөөрөмжийн бүрэн бүтэн байдлыг хангаж, үр ашгийг нэмэгдүүлэх, эрчим хүч хэмнэх нөхцлийг бүрдүүлнэ. (Бага) | Техникийн засвар үйлчилгээний бүртгэл | |
| 2.9 | Биологийн олон янз байдал | | |
| | Нэн ховор, ховордсон амьтан, ургамлыг хамгаалах, өргөн тархацтай амьтан ургамлын нөөцийг зохистой ашиглах, байгалийн бэлчээр, зэрлэг амьтдын дасч идээшсэн нутаг, гол мөрний сав газрыг хамгаалах, амьтны жам ёсны эрхийг хангах асуудлыг хамарсан Амьтны тухай, байгалийн ургамлын тухай зэрэг Монгол улсын байгал хамгаалах цогц хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана. (Гол) | Үйлдвэрлэлийн төлөвлөгөөнд энэ асуудлыг тусгаж, хэрэгжүүлж ажилласан байна. | |
| | Зэрлэг амьтдын жам ёсны эрхийг хангаж, хамгаалах арга хэмжээ авна. (Бага) | Биет үзлэгийн дүн, ярилцлага | |
| 2.10 | Агаар / Дуу чимээ | | |
| | Үйлдвэрлэлийн явцад тааламжгүй үнэр, эсхүл утаа, тоос шороо эсхүл дуу чимээ үүссэн бол хөрш зэргэлдээ газар болон хүрээлэн буй орчинд үзүүлэх сөрөг нөлөөг багасгах арга хэмжээг авна. (Гол) | Биет үзлэгийн дүн, сөрөг нөлөөгбууруул ахаар авсан арга хэмжээний тайлан | |
| 2.11 | Сургалт | | |
| | БОХД-ыг хэвшүүлэх чиглэлээр хүлээсэн үүрэг хариуцлага, чиг үүргийнх нь дагуу ногоочид, жимсчид, ажилчдыг сургалтад хамруулж, энэ талаар бүртгэл хөтлөнө. (Гол) | Сургалтад хамрагдсан тухай бүртгэл, тайлан, ярилцлага | |
| 2.12 | Баримт бичиг ба бүртгэл | | |
| | БОХД-ын бүртгэлийн бичиг баримтыг хоёр жилийн хугацаанд хадгална. (Гол) | Архивын биет үзлэг | |
| | Хуучирсан (хүчингүй болсон) дүрэм, журмыг устгах бөгөөд зөвхөн хүчин төгөлдөр эрх зүйн бичиг баримтыг ашиглана. (Гол) | эрх зүйн баримт бичгийн хүчин төгөлдөр эсэхийг шалгах | |
| 2.13 | Дадлыг хэвшүүлсэн үр дүнг хянаж, шалгах | | |
| | Үйлдвэрлэл, түүхий эд, бүтээгдэхүүнээс шалтгаалан хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх, нөлөөлж болзошгүй нөхцөл байдлыг тогтоох зорилгоор хяналт, шалгалтыг жилд нэгээс доошгүй удаа явуулна. (Гол) | Хяналт шалгалтын тайлан | |

| | | | |
|------|---|---|--|
| | Хяналт, шалгалт болон зөрчил дутагдлын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг гаргаж, хадгална. (Гол) | Засч залруулах арга хэмжээний тайлан | |
| | СОНГОЖ ХЭРЭГЛЭХ ШААРДЛАГУУД | | |
| 2.14 | Үйлдвэрлэгч бүр байгаль орчин, биологийн олон янз байдал, зэрлэг ан амьтдыг хамгаалах менежментийн төлөвлөгөөтэй байна. Энэхүү төлөвлөгөө нь хүрээлэн буй орчин, онгон байгаль, биологийн төрөл зүйлийг тогтоосон суурь судалгаа, зэрлэг амьтдын жам ёсны эрхийг хамгаалж, амьдрах орчны доройтлоос сэргийлэх, биологийн төрөл зүйлийг нэмэгдүүлэх арга хэмжээг нарийвчлан тусгасан байна. (Бага) | байгаль орчин, биологийн олон янз байдал, зэрлэг ан амьтдыг хамгаалах менежментийн төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан | |
| | Үйлдвэрлэгч нь орон нутгийн хүн амын эрх ашиг, амьтан, ургамлын аймгийн жам ёсны эрхийг хүндэтгэн дээдлэж, хүрээлэн буй орчныг хамгаалах, нөхөн сэргээх бодлого боловсруулж, хэрэгжүүлж ажиллана. (Бага) | Бодлогын баримт бичг ба хэрэгжилтийн тайлан | |
| | Үйлдвэрлэгч нь боломжтой бол хиймэл хөрсийг дахин боловсруулах сургалтад хамрагдсан байна. (Бага) | Сургалтын тайлан, мэдээ | |
| | Хөрс ариутгагчийг хэрэглэх үндэслэл, шаардлагыг тогтоосон байна. (Бага) | Хөрс ариутгагчийн ашиглалтын тайлан | |
| | Хөрс ариутгах шаардлагад нийцүүлэн таримал тарихаас татгалзах хугацааг тогтоож, мөрдөж ажиллана. (Бага) | Тариалалт болон хөрс ариутгалын хугацааг харьцуулах | |

Тав. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ба нийгмийн халамжийг сайжруулах дадал (АЭМАБНХСД)

5.1. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ба нийгмийн халамжийг сайжруулах дадал нь ажилчдын эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх, нийгмийн халамжийг сайжруулах зорилготой.

5.2. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ба нийгмийн халамжийг сайжруулах дадал нь 7 (3.1 - 3.7) бүлэгтэй.

5.3. Хөдөлмөрийн насны, ХАА-н анхан шатны үйлдвэрлэл/ ферм дээр байнгын, түр, цагаар ажиллахаар хөдөлмөрийн гэрээ байгуулж, хөдөлмөр эрхэлдэг хүнийг ажилчид гэж ойлгоно.

5.4. Ажилчдад учирч болзошгүй аюулд механик гэмтэл, химийн бодисоор хордох, биологийн бохирдол, цахилгаан, наранд цохиулах, дуу чимээ, стресст өртөх, хэт ядрах, халамжтай холбоотой асуудлууд багтана.

5.5. Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал ба нийгмийн халамжийг сайжруулах дадал тус бүрт хамаарах шаардлага, дотоод хяналтын ажилтан эсхүл хөндлөнгийн аудиторын зүгээс хяналт, шалгалтын үр дүнг тооцох хэлбэр, биелэлтийн төлвийг үнэлэх нөхцлийг Хүснэгт 3-т үзүүлэв.

| № | Шаардлагууд | Үр дүнг тооцох хэлбэр | Биелэлтийн төлөв: Тийм/ Үгүй |
|------------|--|---|------------------------------|
| 3.1 | Химийн бодис | | |
| | Зохих шатны мэдлэг, ур чадвар бүхий, холбогдох сургалтад хамрагдсан ажилчид химийн бодистой харьцаж, түүнийг ашиглана. (Чухал) | Сургалтад хамрагдсан тухай баримт, ярилцлага | |
| | Химийн бодисыг гэрэлтүүлэг сайтай, найдвартай, аюулгүй, зөвхөн эрх бүхий ажилтан нэвтрэхийг зөвшөөрсөн агуулахад хадгална. Агуулахын барилгын хийц, бүтэц нь ажилчдыг хордуулах эрсдлийг хамгийн бага түвшинд байлгахар зохион байгуулагдсан байх ба химийн бодис асгарах, алдагдахад хэрэглэх эмнэлэгийн яаралтай тусламжийн хэрэгслээр тоноглогдсон байна. (Гол) | Биет үзлэг, ярилцлага | |
| | Химийн бодисыг анх ирсэн оригинал саванд нь шошгод заасны дагуу хадгална. Хэрэв химийн бодисыг өөр саванд шилжүүлсэн бол шинэ сав нь химийн бодисын нэр, хэрэглэх тун, давтамжийн талаарх мэдээлэл бүхий шошготой байна. (Гол) | Биет үзлэг, ярилцлага | |
| | Химийн бодисны хоосон савыг зөвхөн тухайн бодисыг хадгалах, тээвэрлэх зорилгоор дахин ашиглах ба бусад зориулалтаар ашиглахыг хориглоно. (Гол) | Биет үзлэг, ярилцлага | |
| | Бүх төрлийн химийн бодис нь аюулгүй ажиллагааны заавартай байна.(Гол) | аюулгүй ажиллагааны заавар | |
| | Аюулгүй ажиллагааны заавартай ажилтан бүр танилцаж, хэрэгжүүлж ажиллах ба тэдгээрийг хүнд харагдаж, уншигдахуйц байрлалд хадаж, нааж, тогтоосон байна. (Гол) | Биет үзлэг, ярилцлага | |
| | Химийн бодис болон бусад шалтгаанаас үүдсэн осол гэмтэлд өртсөн ажилчдад эмнэлэгийн анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх боломжоор бүрэн хангагдсан байна. (Гол) | анхан шатны тусламж, үйлчилгээг үзүүлэх цэг, түүний иж бүрдэл | |
| | Онцгой нөхцөл байдал үүсэхэд баримтлах зааврыг боловсруулж, химийн бодис хадгалах агуулахын шаардлагатай газруудад байрлуулна. (Гол) | Заавар болон биет үзлэгийн дүн | |
| | Ажилчид химийн бодистой харьцах, хэрэглэх, эсхүл дөнгөж шинээр шүршиж, цацсан газарт нэвтрэхдээ хамгаалалтын хувцас, тоног хэрэгсэл ашиглана. Эдгээрийг ургамал хамгааллын бодис хадгалж буй агуулахаас тусад нь хадгална. (Гол) | Биет үзлэг, ярилцлага | |
| | Ажилчдыг химийн бодисын төрлөөс хамааран химийн бодис шүршиж, хэрэглэж байгаа, эсхүл хэрэглэсэн газарт тодорхой хугацаанд нэвтрэхийг хориглох ба хэрэв химийн бодисыг нийтийн эзэмшлийн газарт эсвэл олон нийтэд нээлттэй газарт | Анхааруулах тэмдэг, түүний ашиглалт, биет үзлэг, ярилцлага | |

| | | | |
|-----|--|--|--|
| | хэрэглэсэн бол тухайн газарт тусгайлан тэмдэг тавьж, анхааруулна. (Гол) | | |
| 3.2 | Ажлын нөхцөл | | |
| | Ажилчид нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлага хангасан ажлын байранд ажиллах эрхтэй. Хэрэв үйлдвэрлэлийн орчинд учирч болох аюултай нөхцөл, эрсдлийг бүрэн арилгах боломжгүй тохиолдолд хөдөлмөр хамгаалалтын хэрэгсэл / хувцас олгоно. (Гол) | ажлын байрны нөхцөл, хөдөлмөр хамгаалалтын хэрэгслийн биет үзлэг | |
| | Хөдөө аж ахуйн машин механизм, тоног төхөөрөмж, цахилгаан ба механик багаж хэрэгслийг ашиглахад ажилчдад гэмтэл учруулах эрсдэлгүй, ажлын бэлэн байдалд байлгана. (Гол) | Техникийн засвар үйлчилгээний бүртгэл | |
| | Машин механизм, тоног төхөөрөмж тэдгээрийн дагалдах хэрэгслийг ажиллуулахад баримтлах аюулгүй ажиллагааны зааврыг боловсруулж, батлан, ажилчдад олгох ба харагдаж, уншигдахуйц газарт байршуулсан байна. (Гол) | аюулгүй ажиллагааны заавар, биет үзлэг, ярилцлага | |
| 3.3 | Хувийн эрүүл ахуй | | |
| | Фермерүүд болон ажилчид өөрсдийн эрүүл мэндийг хамгаалах, хувийн ариун цэврийг хэрхэн сахих талаар сургалтад хамрагдсан байна. (Гол) | Сургалтын тайлан бүртгэл | |
| | Хувийн ариун цэврийг талаархи зааврыг ажилчдад танилцуулж, харагдаж, уншигдахуйц газарт байршуулсан байна. (Гол) | Хувийн ариун цэврийг сахих заавар | |
| | Ажилчдыг 6 сар/эсхүл жил тутам эрүүл мэндийн үзлэгт хамруулж, 5 жилийн хугацаанд бүртгэл, тайланг хадгална. (Бага) | эрүүл мэндийн үзлэгийн тайлан бүртгэл | |
| | Эрүүл ахуйн шаардлага хангасан, хүрэлцэхүйц тооны бие засах, гар угаах газар, шүршүүртэй байна. (Гол) | Биет үзлэг | |
| | Бохир зайлуулах шугам нь ажилчдын эрүүл ахуйд сөргөөр нөлөөлж, бохирдол үүсгэхээргүй байдлаар төлөвлөгдөж, шийдэгдсэн байна. (Гол) | Биет үзлэг | |
| | Ажил олгогч нь ажилчдын эрүүл мэндийн даатгалын төлбөрийг хийдэг бол тэдгээрийн эрүүл мэндтэй холбоотой ноцтой асуудлыг холбогдох эрх бүхий байгууллагад мэдэгдэнэ. (Гол) | Мэдэгдсэн тухай бүртгэл, тайлан | |
| | Тариалангийн талбай, бэлтгэх цех, зоорь агуулах, савлагааны цех рүү мал, амьтан нэвтрэх боломжийг хязгаарлах арга хэмжээ авна. (Гол) | Биет үзлэг | |
| 3.4 | Ажилчдын нийгмийн халамжийн асуудал | | |
| | Аливаа асуудлаар ажилчидтай эрх тэгш харьцана. (Гол) | Ярилцлага | |
| | Нас, хүйс болон бусад шалтгааны улмаас ажилчдын цалин хөлсийг ялгавартай тогтоож болохгүй. (Гол) | Ярилцлага | |
| | Амралтын байр нь хүн амьдрах зориулалттай, эрүүл ахуйн шаардлага хангасан хоол хүнс хадгалах хөргөгч, хөлдөөгчтэй, гал тогооны хэсэгтэй, гар угаах тосгуур, ундны усаар хангагдсан байна. (Гол) | Биет үзлэг | |
| | Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ, ажлын цаг зэрэг нь хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцсэн байна. (Чухал) | Цалингийн цэс, бүртгэл, ярилцлага | |

| | | | |
|-----|--|---|--|
| | Хэрэв ажлын байр нь зэрлэг амьтдын довтолгоонд өртөх магадлалтай бол ажлын байрыг хамгаалсан байна. (Гол) | Биет үзлэг, тайлан | |
| 3.5 | Сургалт | | |
| | Талбайд ажиллахад эрүүл мэнд, аюулгүй байдалд нь учирч болзошгүй эрсдлийн талаар ажилчдад мэдэгдсэн байна. (Гол) | Ярилцлага | |
| | Ажилчдыг аюулгүй ажиллагааны шаардлагууд (аюулгүйн дүрэм), осол аваар, онцгой нөхцлийн үед авах арга хэмжээ, эмнэлэгийн анхан шатны тусламжийн дадал, химийн бодистой аюулгүй харьцах заавар ба хувийн эрүүл ахуйн талаар сургалтад хамруулна. (Гол) | Ярилцлага, биет үзлэг | |
| | Ажилчдыг өөрсдийнх нь хариуцсан чиг үүрэгт хамаарах тээврийн хэрэгсэл, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжийг ажиллуулах, ашиглах талаар сургалтад хамруулах ёстой. (Гол) | Сургалтад хамрагдсан тайлан, баримтууд, ярилцлага | |
| | "Байгаль орчны боловсрол ба мэдлэг" хөтөлбөрүүд, "Хүмүүн-амьтан зэрэгцэн оршихуй" зэрэг сургалтыг фермерийн бүх ажилчдад зориулан зохион байгуулна. (Бага) | Сургалтад хамрагдсан тайлан, баримтууд, ярилцлага | |
| | Сургалтын хэрэгцээг жилд нэг удаа хянаж, төлөвлөнө. (Бага) | Төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан | |
| 3.6 | Баримт бичиг ба бүртгэл | | |
| | ХААЗД-ын тайлан бүртгэлийг хоёр жилийн хугацаанд хадгална. (Гол) | Архивын биет үзлэг | |
| | Хуучирсан (хүчингүй болсон) баримт бичгийг устгах бөгөөд зөвхөн одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй баримт бичгийг ашиглана. (Гол) | баримт бичгийн шалгалт | |
| 3.7 | Дадлыг хэвшүүлсэн үр дүнг хянаж, шалгах | | |
| | Ажилчдын хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдалтай холбоотой бүх дадлыг жил бүр нэгээс доошгүй удаа хянан үзэж, тэдгээрийг зөв хийж гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж, аливаа зөрчил дутагдлыг арилгах арга хэмжээ авна. (Гол) | Хяналт шалгалтын дүн, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн тайлан | |
| | Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн халамжийн талаар ирүүлсэн гомдол, санал, гомдлыг шийдвэрлэх талаар авсан арга хэмжээг тайлагнаж, хадгална. (Гол) | Гомдол, саналын дэвтэр, авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн тайлан | |
| | СОНГОЖ ХЭРЭГЛЭХ ШААРДЛАГУУД | | |
| | Ажилчдын эрүүл мэнд, аюулгүй байдал, нийгмийн халамжийг Удирдлагын багаас 1 гишүүн хариуцана. (Бага) | Томилж, чиг үүргийг нь тодорхойлсон шийдвэр | |

| | | | |
|--|---|----------------------------|--|
| | Ажилчид, менежерүүдийн хооронд хоёр талт уулзалтуудыг тогтмол зохион байгуулж, тайлагнаж, хадгална. (Бага) | Хурал, уулзалтын тэмдэглэл | |
| | Ургамал хамгааллын бодистой харьцдаг бүх ажилчдыг сайн дурын эрүүл мэндийн үзлэгт жил бүр хамруулна. (Бага) | Эрүүл мэндийн үзлэгийн дүн | |

Зургаа. Бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадал (БЧЭД)

6.1. Бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадал нь бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилготой.

6.2. Бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадал нь 10 (4.1 - 4.10) хэсгээс бүрдэнэ.

6.3. Бүтээгдэхүүний чанарт гадаад байдал (өнгө, бүтэц, хэлбэр, хэмжээ), орц, найрлага (усанд уусах чанар, хуурай бодисын агууламж, хөөсрөлтийн зэрэг, чийгшлийн хэмжээ), шимт чанар (тэжээллэг бодисын агууламж, хадгалах хугацаа) зэрэг үзүүлэлтүүд хамаарна.

6.4. Бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадал тус бүрт хамаарах шаардлага, дотоод хяналтын ажилтан эсхүл хөндлөнгийн аудиторын зүгээс хяналт, шалгалтын үр дүнг тооцох хэлбэр, биелэлтийн төлвийг үнэлэх нөхцлийг Хүснэгт4-т үзүүлэв.

Хүснэгт4

| № | Шаардлагууд | Үр дүнг тооцох хэлбэр | Биелэлтийн төлөв: Тийм/Үгүй |
|-----|--|--|-----------------------------|
| 4.1 | Чанарын төлөвлөгөө | | |
| | Тариалалт, ургац хураалт, ургац хураалтын дараах үе шатанд бүтээгдэхүүний чанарыг хангахад чухал шаардлагатай дадлыг тодорхойлж, хэвшүүлэх төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлнэ. (Гол) | Төлөвлөгөө, түүний хэрэгжилтийн тайлан | |
| 4.2 | Үр, үрсэлгээ, суулгац | | |
| | Өвчний шинж тэмдэггүй, сайн чанарын, зах зээлийн шаардлагыг хангасан, гарал үүсэл нь баталгаажсан хүнсний ногоо, жимс жимсгэний үр, үрсэлгээ, суулгац (үр, үндэс, тарьц)-ыг тусгай зөвшөөрөлтэй үр үржүүлгийн газраас худалдаж авна. Үр, үрсэлгээ, суулгацыг худалдан авсан тухай бүртгэлийг хөтөлж, хадгална. (Бага) | Худалдан авалтыг нотлох баримт бичиг | |
| 4.3 | Бордоо ба хөрс сайжруулагч нэмэлтүүд | | |
| | Бордоо, хөрс сайжруулагчийг хэрэглэхдээ таримлын төрөл, эрх бүхий байгууллагаас өгсөн зөвлөмжид тулгуурлах ба зааврын дагуу, үр ашигтай хэрэглэнэ. Органик бордоо үйлдвэрлэх барилга байгууламж, тоног төхөөрөмжийг төлөвлөж, барихдаа таримлыг дам бохирдлоос сэргийлэх арга хэмжээг авсан байна. Бордоо, хөрс сайжруулагчийн хэмжээ, хэрэглэсэн огноо, бордоо, хөрс сайжруулагчийг хэрэглэсэн болон нийлүүлсэн ажилтны нэрийг тодорхой заасан бүртгэлийг хөтөлсөн байна. (Гол) | Зөвлөмж, заавар, ашиглалтын тайлан, биет үзлэг | |
| 4.4 | Ус | | |

| | | | |
|-----|---|--|--|
| | Таримлын чийгийн хэрэгцээ, бороо, усны түвшин, хөрсний чийгийн түвшинд үндэслэн усалгааг хийнэ. Усалгаа хийсэн огноо, талбайн байршил, усны хэмжээ зэргийг нарийвчлан бүртгэсэн бүртгэлийг хөтөлж, хадгална. (Гол) | Усалгааны бүртгэл, тайлан | |
| 4.5 | Химийн бодис | | |
| | Фермерүүд эсхүл ажилчид химийн бодисыг хэрхэн ашиглах талаар сайтар бэлтгэгдсэн байна. (Гол) | Сургалтын тайлан, ярилцлага | |
| | Тухайн тарималд зориулсан химийн бодисыг тусгай зөвшөөрөлтэй нийлүүлэгчээс авах бөгөөд эрх бүхий байгууллагын зөвлөмж эсхүл шошго дахь зааврын дагуу хэрэглэнэ. (Гол) | Худалдан авалтыг нотлох баримт бичиг | |
| | Хортон шавж химийн бодист дасал болохоос сэргийлж, химийн бодисыг сэлгэх, ургамал хамгааллын бусад арга хэмжээг ээлжлэн хэрэглэх стратегийг баримтлана. (Гол) | Стратеги ба түүний хэрэгжилт, биет үзлэг | |
| | Химийн бодисыг цацаж, хэрэглэхэд ашигладаг тоног төхөөрөмж зөв ажиллаж байгаа эсэхийг нягталж, ажлын бэлэн байдлыг хангана. (Бага) | Техникийн засвар үйлчилгээний бүртгэл | |
| | Химийн бодисын нэр, хэрэглэсэн шалтгаан, огноо, тун, хэрэглэсэн арга, цаг агаарын байдал, химийн бодисыг хариуцаж, хэрэглэсэн ажилтны нэр зэрэг мэдээллийг агуулсан бүртгэлийг хөтөлж, хадгална. (Гол) | Ашиглалтын тайлан | |
| 4.6 | Ургац хураах, бүтээгдэхүүнтэй харьцах | | |
| | Ургац хураах | | |
| | Таримлын болцыг тодорхойлж, ургац хураалтын тохиромжтой хугацааг тогтооно. Ургац хураалтыг өглөө эрт, өдрийн хамгийн сэрүүн үед хийнэ. (Гол) | Таримлын болцын индекс болон ургац хураалтын мэдээ | |
| | Ургац хураалтад хэрэглэх тоног төхөөрөмж, хайрцаг сав, уут, шуудай нь эрүүл ахуйн шаардлагад нийцсэн байна. Савыг хэт дүүргэхгүй. Уут, шуудайд савлах тохиолдолд хатуу сав эсхүл бусад өөр хатуу халхавч ашиглан гэмтлээс сэргийлнэ. Сав, хайрцагт савласан тохиолдолд чийгийн алдагдлыг багасгахын тулд бүтээнэ. Таримлыг гэмтлээс сэргийлэх зорилгоор савыг дээр дээрээс нь давхарлаж, хураахаар тусгайлан үйлдвэрлэснээс бусад тохиолдолд сав, хайрцгийг давхарлаж, ачиж, хурааж болохгүй. (Гол) | Биет үзлэг | |
| | Хураасан ургацыг сүүдэрт байрлуулж, аль болох богино хугацаанд талбайгаас ачина. (Гол). | Биет үзлэг | |
| | Бүтээгдэхүүнийг цэвэрлэх, угаах, ангилах ба савлах | | |
| | Бүтээгдэхүүнийг цэвэрлэж, угаахад ундны ус хэрэглэх ба тогтмол сольж, өвчин үүсгэгч бичил биетийн бохирдлоос сэргийлнэ. (Гол) | Биет үзлэг | |
| | Бүтээгдэхүүнийг шидэх, унагаах, бусад байдлаар гэмтэл учруулахаас зайлсхийж, механик гэмтэл учрахаас сэргийлнэ. (Гол) | Биет үзлэг | |
| | Сэрүүн газар, саравчинд савлаж, хадгална. (Бага) | Биет үзлэг | |

| | | | |
|------|--|---|--|
| | Бүтээгдэхүүнийг газар эсхүл шалан дээр шууд байрлуулж болохгүй. (Гол) | Биет үзлэг | |
| | Хэрэглэгч болон зах зээлийн шаардлагын дагуу бүтээгдэхүүнийг ангилж, савлана. (Гол) | Чанарын хяналтын тэмдэг бүхий сав баглаа боодлыг шалгах | |
| | Хадгалалт ба тээвэрлэлт | | |
| | Бүтээгдэхүүнийг нь шаардлагатай газарт нь богино хугацаанд тээвэрлэж, хүргэнэ. Ачиж, тээвэрлэх логистикийг хурдавчлах боломжгүй бол бүтээгдэхүүнийг зохистой хэмд хадгална. (Гол) | Биет үзлэг болон ачилтын баримт бичиг | |
| | Бүтээгдэхүүний чанар муудахаас сэргийлэх зорилгоор тээвэрлэлтийн явцад түүнийг хучиж, зохих хэмийг барина. (Гол) | Биет үзлэг болон ачилтын баримт бичиг | |
| | Машины тээшний бохирдлыг цэвэрлэж, ариутгах ба хоорондоо зохицдоггүй бүтээгдэхүүнийг хольж тээвэрлэхээс зайлсхийнэ. (Бага) | Биет үзлэг болон ачилтын баримт бичиг | |
| 4.7 | Ул мөрийг мөшгих ба эргүүлэн татах тогтолцоо | | |
| | Таримлыг хураасан талбайн байршил, нэрийг талбайн зураглалтай дүйцүүлж, кодлон, бүртгэх ба бүтээгдэхүүнийг савлахдаа холбогдох бүртгэлийн дугаарыг мөн адил тэмдэглэнэ. (Гол) | Талбайн зураглал, код, биет үзлэг | |
| | Ачилт хийсэн огноо, ачигдсан бүтээгдэхүүний тоо хэмжээ, хүрэх газрыг тэмдэглэж, бүртгэл хөтөлнө. (Гол) | Биет үзлэг болон ачилтын баримт бичиг | |
| 4.8 | Сургалт | | |
| | Тариаланчид болон бусад ажилчдыг өөрт нь хамаарах чиглэлийн дагуу бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадлын сургалтад хамруулж, энэ тухай бүртгэл хөтөлж, хадгална. (Бага) | Сургалтын тайлан | |
| 4.9 | Баримт бичиг ба бүртгэл | | |
| | Бүтээгдэхүүний чанарыг эрхэмлэх дадалд хамаарах бүртгэлийг хоёр жилийн хугацаатай хадгална. (Гол) | Архив | |
| | Хүчингүй, хуучин бичиг баримтыг устгаж, зөвхөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хувилбарыг хэрэглэнэ. (Гол) | Баримт бичгийн эрх зүйн чадамжийг шалгана | |
| 4.10 | Дадлыг хэвшүүлсэн үр дүнг хянаж, шалгах | | |
| | Бүх дадлын хэрэлэгжилтийг жил бүр нэгээс доошгүй удаа хянан үзэж, тэдгээрийг зөв хийж гүйцэтгэж буй эсэхэд хяналт тавьж, аливаа зөрчил дутагдлыг засаж залруулах арга хэмжээ авна. (Гол) | Хяналт шалаглтын дүн, хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн | |
| | Бүтээгдэхүүний чанартай холбоотой бүх өргөдөл, гомдлыг шийдвэрлэж, зөрчил дутагдлыг засч залруулсан тухай тэмдэглэлийг хөтөлж, бүртгэлжүүлэн, хадгална. | Гомдын мөрөөр хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | |

| СОНГОЖ ХЭРЭГЛЭХ ШААРДЛАГУУД | | | |
|-----------------------------|---|---|--|
| | Химийн бодисыг шошгод тусгасаны дагуу хэрхэн зөв харьцаагаар хольж, зохистой хэрэглэх талаарх зааврыг боловсруулж, батлан, хэрэгжүүлнэ. | Батлагдсан заавар болон ажилчдын мэдлэгийг шалгах | |
| | Савласан бүтээгдэхүүнийг фермерийн аж ахуйд хадгалж буй тохиолдолд дулааны хэм болон чийгшлийг тэмдэглэж, бүртгэнэ. | Хадгалалтын горимын бүртгэл, тэмдэглэгээ | |

Зургаа. Нийтлэг дадал

6.1.Нийтлэг дадал нь ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдах тариаланчийн хэвшүүлэх нийтлэг дадал болон нэг хуулийн этгээд, аж ахуйн нэгжийн дор бүлэг баталгаажуулалтад хамрагдах хүсэлтэй хоршоо, нөхөрлөлийн хэлбэрээр газар тариалангийн үйл ажиллагаа явуулж буй фермерүүдийн зүгээс дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд хэвшүүлэх шаардлагатай дадлыг тус тус агуулсан.

6.2.Дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлэхэд заавал бичгээр үйлдсэн албан ёсны гэрээ, хоршоо, нөхөрлөлийн үйл ажиллагааг зохицуулсан дүрэмтэй байна.

6.3. Нийтлэг дадал тус бүрт хамаарах шаардлага, дотоод хяналтын ажилтан эсхүл хөндлөнгийн аудиторын зүгээс хяналт, шалгалтын үр дүнг тооцох хэлбэр, биелэлтийн төлвийг үнэлэх нөхцлийг Хүснэгт5-д үзүүлэв.

Хүснэгт5

| № | Шаардлагууд | Үр дүнг тооцох хэлбэр | Биелэлтийн төлөв: Тийм/Үгүй |
|-----|---|--|-----------------------------|
| | Бие даасан фермерийн аж ахуй | | |
| 5.1 | Хууль эрх зүй: Өргөдөл гаргагчийн баталгаажуулалтад хамрагдах талбай нь өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээтэй эсхүл газар өмчлөгч, эзэмшигч ба өргөдөл гаргагчийн хооронд байгуулсан газар ашиглах тухай гэрээнд хөдөө аж ахуйн чиглэлийн үйл ажиллагаа явуулж, баталгаажуулалтад хамрагдах эрхийг өргөдөл гаргагчид олгосон байна. (Гол) | Гэрээ, эрхийн гэрчилгээ | |
| 5.2 | Гадны зочинд тавих шаардлага: ХААЗД-ыг хэрэгжүүлж буй фермерийн аж ахуй болон талбайд гадны этгээд зочлоход зочны болон бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах зорилгоор ХАААШҮЭ/фермерийн ажилтнууд дагаж мөрдөж буй шаардлагуудыг нэгэн адил дагаж мөрдөхийг зочноос шаардаж, биелэлтийг хангуулна. (Гол) | Гадны зочид дагаж мөрдөх заавар дүрмийг харагдахуйц газар байршуулсан байна. | |
| 5.3 | Гомдол барагдуулах | | |
| | Бүх гомдлыг зохих ёсоор бүртгэж, үр дүнтэй шийдвэрлэнэ. Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар бүртгэл хөтөлнө (Гол). | Авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан | |
| | Өргөдөл, гомдлыг барагдуулах үр дүнтэй бүтэц, зохион байгуулалтыг бүрдүүлсэн байна. | Бүтэц, зохион байгуулалт, эрх хэмжээг | |

| | | | |
|------|--|---|--|
| | | тогтоосон шийдвэр, биет үзлэгийн дүн | |
| 5.4 | Талбайн дэлгэрэнгүй мэдээлэл: Талбай ба үйлдвэрлэлийн нэгж тус бүрийг ХАААШҮЭ/фермерийн төлөвлөгөө эсхүл газрын зураг дээр зохих ёсоор иш татаж, тусгасан байна. (Гол) | Фермерийн зураг, схем | |
| 5.5 | Дотоод хяналт: Дотоод хяналтыг жилд нэгээс доошгүй удаа гүйцэтгэнэ (гол) | Хяналтын хуудас | |
| 5.6 | Шалгалт тохируулга: ХАААШҮЭ/фермер нь шаардлагатай тохиолдолд “Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай” хууль тогтоомжийн дагуу тоног төхөөрөмж, хэмжих хэрэгслийн шалгалт тохируулгыг хийлгэнэ. | Шалгалт тохируулга хийлгэсэн тухай баримт | |
| | Хоршоо, нөхөрлөл (бүлгээр баталгаажуулах) | | |
| 5.7 | Хууль эрх зүйн шаардлага | | |
| | Тариаланчид хорших эсхүл нөхөрлөл байгуулан бүлгийн баталгаажуулалтад хамрагдах бол Хоршооны тухай болон Органик хүнсний хууль тогтоомжийг баримтлах ба зохих журмын дагуу бүртгүүлсэн байна. (Гол) | Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ эсхүл хамтын баталгаажуулалтын байгууллагын бүртгэлийн гэрчилгээ | |
| | Хоршоо, нөхөрлөл нь ХААЗД-ыг хэрэгжүүлэх бүтэц, бүрэлдэхүүнээ тодорхойлж, бүтээгдэхүүн үйлдвэрлэх, удирдлага зохион байгуулалтыг хэрэгжүүлэх талаар гишүүдийн үүрэг хариуцлагыг тодорхойлсон байна. (Гол) | Байгууллагын бүтэц, зохион байгуулалт, чиг, үүргийг тодорхойлсон зураглал, бүдүүвч | |
| | Хоршоо, нөхөрлөлийн гишүүдийн хоорондын харилцаа, хамтын ажиллагааг тодорхойлж, тогтоосон байна. (Гол) | Эрх үүргийн хуваарилалтыг харуулсан баримт бичиг | |
| 5.8 | Бичмэл гэрээ: Хувь хүн болон фермерийн аж ахуйн дэлгэрэнгүй мэдээлэл, хоршоо, нөхөрлөлийн дүрэм, ХААЗД-ын стандартаар тогтоосон шаардлагыг биелүүлэх, биелүүлээгүй тохиолдолд авах арга хэмжээг агуулсан гэрээг хоршоо, нөхөрлөлийн гишүүн тус бүр бичгээр, гарын үсэг зурж байгуулна. (гол) | Гэрээ | |
| 5.9 | Үйлдвэрлэгчийн бүртгэл: Хоршоо, нөхөрлөлийн талаар дэлгэрэнгүй мэдээлэл, түүний бүх гишүүдийн гүйцэтгэж буй үүрэг, тариалангийн болон үйлдвэрлэлийн талбайн хэмжээ, таримлын төрөл, дотоод хяналтын тайлан, илрүүлсэн зөрчлийн талаар бүртгэл хөтөлнө. (гол) | Гишүүдийн бүртгэл | |
| 5.10 | Байгууллагын бүтэц | | |

| | | | |
|------|--|--|--|
| | Байгууллагын бүтэц, зохион байгуулалт нь ХААЗД-ын стандартыг хэрэгжүүлэхэд шаардагдах нөөцийг бүрдүүлэх боломжтой байна. (Гол) | Байгууллагын бүтэц болон ажиллаж буй боловсон хүчний нөөцийн уялдаа холбоо | |
| | ХААЗД-ын стандартын шаардлагыг хангах чиглэлээр гүйцэтгэх үндсэн үүрэг, хариуцлагыг тогтоож, эзэнжүүлсэн байна. (Гол) | Үүрэг, хариуцлагын биелэлтийг шалгах | |
| | Шийдвэр гаргах эрх мэдлийг хуваарилж, эзэнжүүлсэн байна. (Гол) | Эрх мэдэл олгосон шийдвэр | |
| 5.11 | Ажилтнуудад зориулсан ур чадвар, сургалт | | |
| | Хоршоо, нөхөрлөл нь сургагч багш, чанарын менежер, дотоод хяналтын ажилтан, менежер гэх мэт бүлгээр баталгаажуулах үйл ажиллагааг хариуцсан үндсэн ажилтнуудын мэдлэг, чадварыг үнэлсэн байна. (Гол) | Шаардлагатай мэдлэг, ур чадварыг эзэмшсэн эсэхийг шалгасан тайлан, мэдээ | |
| | Хоршоо, нөхөрлөл нь ХААЗД-ын баталгаажуулалтыг хариуцахаар томилогдсон ажилтнууд сайтар бэлтгэгдсэн, чадвартай, шаардлагын дагуу ажиллаж буйг баталгаажуулсан байна. (Гол) | Ярилцлага ба сургалтын бичлэг, зураг | |
| | Хоршоо, нөхөрлөл нь томилогдсон ажилтны мэдлэг, ур чадварыг ХААЗД-ын хөтөлбөрт тусгагдсан шаардлагад нийцүүлэн үнэлж, шаардагдах мэргэшлийн сургалтын хэрэгцээг тодорхойлж, сургалтад хамрагдсан талаарх бүртгэлийг хөтөлж, хадгална. (Гол) | Сургалтын төлөвлөгөө, хэрэгжилтийн тайлан | |
| | Хоршоо, нөхөрлөл нь дотоод хяналтын байцаагч нарыг ХААЗД-ын хөтөлбөрт тусгагдсан аудитын хяналтын горим, ХААЗД-ын шаардлагыг бүрэн судалж, бэлтгэгдсэн эсэхийг нягталж, холбогдох сургалтанд хамруулж, үнэлгээ өгнө. (Гол) | Биет үзлэгийн дүн, сургалтын тайлан, мэдээ | |
| 5.12 | Чанарын гарын авлага | | |
| | Хоршоо, нөхөрлөл нь баталгаажуулалтын хамрах хүрээ, удирдлага, дотоод хяналт, бодлого, үйл ажиллагааны дүрэм, гишүүд болон тодорхой чиг үүрэг гүйцэтгэх гишүүдийг бүртгэх, томилох асуудлыг багтаасан "чанарын гарын авлага" -ыг боловсруулж, батлуулна. | Чанарын гарын авлага, түүний хэрэгжилт | |
| | Гарын авлага нь хоршоо, нөхөрлөл тавигдаж байгаа болон ХААЗД-ын хөтөлбөрийн шаардлагатай нийцэж буй эсэхийг тогтмол нягтлаж, шинэчилнэ. (Гол) | Чанарын гарын авлагыг шинэчилж, өөрчилснийг нягтлах | |
| | Хоршоо, нөхөрлөл нь ХААЗД-ын хэрэгжилт, түүнийг сайжруулах талаар авч хэрэгжүүлж буй арга хэмжээ хууль, эрх зүйн актад орсон өөрчлөлтийн | Ярилцлага авах, баримт | |

| | | | |
|------|--|---|--|
| | талаарх аливаа мэдээллийг шинэчлэн тухай бүр нийтэд мэдээлэх тогтолцоог бүрдүүлэн, үр дүнтэй ажиллуулна. (Гол) | бичгийн шалгалт | |
| 5.13 | Баримт бичгийн хяналт | | |
| | Бүх баримт бичгийг бүрдүүлэх, хянах, түр хадгалах, архивлах тогтолцоо бүрдүүлсэн байна. (Чухал) | Баримт бичгийн бүрдэл, хадгалалтыг түүврийн аргаар шалгах | |
| | Өдөр тутам хэрэглэгддэг ХААЗД-ын үндсэн баримт бичгийн жагсаалтыг гаргах ба үүнд чанарын гарын авлага, үйл ажиллагааны дүрэм, заавар, бүртгэлийн загвар болон бусад байгууллагаас гаргасан үндсэн бичиг баримтыг багтаасан байна. (Гол). | Үндсэн баримт бичгийн шалгалт | |
| | Баримт бичгийн хяналтыг үр дүнтэй явуулж буйг харруулах бүртгэл, тайлантай байна. (Гол) | Баримт бичгийг хянах тогтолцоог биет үзлэгээр дүгнэх | |
| | Бусад байгууллагаас гаргасан баримт бичгийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллах шалгуурыг тогтооно. (Гол) | Шалгуур үзүүлэлтийг баталсан шийдвэр | |
| 5.14 | Гомдлыг барагдуулах | | |
| | Өргөдөл, гомдлыг хүлээн авах, бүртгэх, дүн шинжилгээ хийх, зөрчил дутагдлын шалтгааныг олж тогтоох, шийдвэрлэх арга зам, авсан арга хэмжээ, үр дүнгийн талаар мэдээлэх зэрэг үе шатыг хамарсан ХААЗД-ын талаархи бүх гомдол, зөрчлийг шийдвэрлэх журамтай байна. (Гол) | Өргөдөл, гомдлыг барагдуулах журам | |
| | Гомдол барагдуулах хугацааг тогтоосон байна. (Гол) | Өргөдөл, гомдлыг барагдуулах журам | |
| | Гомдолтой холбоотой мэдээллийг бүртгэх тогтолцоотой байна. (Гол) | Бүртгэл, тайлан | |
| | Шаардлагатай тохиолдолд нууцлалыг хадгалах зохицуулалттай байна. (Гол) | Нууцын зэргийг тогтоосон шийдвэр | |
| 5.15 | Дотоод аудит | | |
| | Хоршоо, нөхөрлөлийн гишүүн тус бүр ХААЗД болон дотоод хяналтын шаардлагад нийцэж буй эсэхэд аудит хийх тогтолцоог бүрдүүлсэн байна. (Чухал) | Дотоод хяналтын хуудас, тайлан | |
| | Дотоод хяналтын ажилтны ур чадварт тавих шаардлагыг тогтоосон байна. (Гол) | Баримт бичиг | |
| | Дотоод хяналтыг гүйцэтгэх, үр дүнг нягтлах, дотоод хяналтын мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлсон журмыг боловсруулж, батлуулан, мөрдөж ажиллана. (Гол) | Дотоод хяналтын ажилтны хяналтын хуудас, | |

| | | | |
|------|---|--|--|
| | | залруулах ба урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаарх мэдээлэл | |
| 5.16 | Зөрчил, залруулах арга хэмжээ, торгууль шийтгэвэр | | |
| | Залруулах арга хэмжээг төлөвлөх, бүртгэх журмыг боловсруулж, хэрэгжүүлнэ. Үүнд зөрчил дутагдал гарсан шалтгаан, тэдгээрийг залруулахад шаардлагатай үйл ажиллагааг үүрэгжүүлэх, хэрэгжүүлэх хугацаа зэргийг тодорхойлж, оруулсан байна. (Чухал) | Зөрчил дутагдлыг залруулах журам | |
| | Торгууль ба шийтгэвэр – Хоршоо, нөхөрлөл нь шаардлагад нийцээгүй үйл ажиллагаа явуулсан гишүүдэд торгууль, шийтгэвэр хэрхэн ногдуулах асуудлыг журамласан байна. Үүнд гишүүний бүртгэлийг түдгэлзүүлэх, бүртгэлээс хасах тухай мэдэгдлийг баталгаажуулалтын байгууллагад шуурхай мэдэгдэх асуудлыг зохицуулсан байна. Гишүүнд торгууль, шийтгэвэр ногдуулах асуудлыг хоршоо, нөхөрлөл ба гишүүний хооронд байгуулсан гэрээгээр зохицуулсан байна. (Чухал) | Торгууль ба шийтгэвэрийг ногдуулах механизм | |
| | Зөрчил, залруулах арга хэмжээ, торгууль шийтгэвэртэй холбоотой бүх мэдээллийн талаар бүртгэл хөтөлнө. (Гол) | торгууль шийтгэвэрийн бүртгэл, тайлан | |
| 5.17 | Ул мөрийг мөшгин тогтоох ба тусгаарлах | | |
| | ХААЗД-ын баталгаажуулалтын тэмдэгтэй бүтээгдэхүүний ул мөрийг бүртгэлтэй ХАААШҮЭ/фермер хувь хүн болон фермерийн аж ахуй хүртэл мөшгин тогтоох боломжийг бүрдүүлсэн байна. ХААЗД-ын баталгаажуулалтын тэмдгийг буруу ашиглах, ХААЗД-ын баталгаажуулалт хийгдсэн болон хийгдээгүй бүтээгдэхүүнийг хольж хэрэглэх эрсдлийг багасгах талаар үр ашигтай тогтолцоог бүрдүүлж, хэрэгжүүлж ажиллана. (Чухал) | Ул мөрийг мөшгих тогтолцоо болон бүртгэл | |
| | Талбайн бүртгэл нь бүтээгдэхүүний баталгаажуулалт, бүртгэлтэй уялдсан байна. Ингэснээр бүтээгдэхүүнийг худалдан авсан баримтад үндэслэн түүнийг хураах, тээвэрлэх, хураалтын дараа цэвэрлэх, ангилах, савлах, хадгалах, түгээх зэрэг бүх үе шатыг хамарсан үйл ажиллагаатай танилцаж, ул мөрийг мөшгин тогтоох боломж бүрдэнэ. (Чухал) | Ул мөрийг мөшгих тогтолцоо болон бүртгэл | |
| 5.18 | Баталгаажсан бүтээгдэхүүнийг буцаан болон татан авах: Хүнсний түүхий эд, бүтээгдэхүүнийг татан авах, устгах, дахин боловсруулах журмын дагуу бүтээгдэхүүнийг зах зээлээс буцаан болон татан авах тогтолцоог бүрдүүлж, жил бүр үр дүнг хянаж байна. (Чухал) | Бүтээгдэхүүнийг зах зээлээс буцаан болон татан авах тогтолцоо болон түүний хэрэгжилт | |

| | | | |
|------|--|---|--|
| 5.19 | Савлагааны цех: Хэрэв хоршоо, нөхөрлөл нь нэг буюу хэд хэдэн савлагааны цехтэй бол тэдгээр нь тус бүрдээ ХААЗД-ын шаардлагыг хангасан байна. (Чухал) | Савлагааны цех тус бүрийг хянаж, шалгах | |
| 5.20 | Нийлүүлэгчтэй гэрээ байгуулах: ХААЗД-ын баталгаажуулалтын тэмдэг, мэдэгдлийг буруугаар ашиглахаас урьдчилан сэргийлэх зорилгоор хоршоо, нөхөрлөл нь өөрийн худалдан авагчтайгаа энэ асуудлыг зохицуулсан гэрээг бичгээр үйлдэнэ. (Чухал) | Гэрээ | |
| 5.21 | Туслан гүйцэтгэх гэрээ: Туслан гүйцэтгэгчийг гэрээгээр ажиллуулж байгаа тохиолдолд дараах асуудлыг багтаасан журмыг баталж, хэрэгжүүлж ажиллана: а. гүйцэтгэж буй ажил, үйлчилгээ нь ХААЗД-ын шаардлагад нийцсэн байх; б. ур чадварыг нь үнэлж, тайлагнах; с. хоршоо, нөхөрлөлийн чанарын тогтолцооны хүрээнд үйл ажиллагаа явуулах (Чухал ач холбогдолтой) | Туслан гүйцэтгэгч ажиллуулах журам | |

Долоо. Хүнсний ногоо, жимс, жимсгэний тариалалтад ХААЗД-ыг нэвтрүүлэх ажлыг үндэсний хэмжээнд зохион байгуулах бүтэц

7.1. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.1 ба 23.2 дахь хэсэгт тус тус заасны дагуу Хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн ХААЗД-ын Үндэсний Зөвлөлийг (Цаашид “Үндэсний зөвлөл” гэх) байгуулна.

7.2. Үндэсний зөвлөл нь хүнсний чиглэлийн үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд ХААЗД-ыг дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар, стандарт, техникийн зохицуулалтыг боловсруулах, хэрэгжилтэд хяналт тавих, ХААЗД-ын тохирлын үнэлгээг үндэсний хэмжээнд төлөвлөх, удирдан зохион байгуулах чиг үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

7.3. Үндэсний зөвлөл үйл ажиллагаандаа Хүнсний тухай хууль, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хууль, Органик хүнсний тухай хууль, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хууль, Байгаль орчны багц хуулиуд болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

7.4. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 23 дугаар зүйлийн 23.2 дахь хэсэгт заасны дагуу Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны зардлыг улсын төсвөөс санхүүжүүлнэ.

7.5. Үндэсний Зөвлөл нь 11 хүний бүрэлдэхүүнтэй байх ба Хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэдгээрийг томилж, чөлөөлнө.

7.6. Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага, Итгэмжлэлийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага, Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг, Хүнсчдийн холбоо, Монголын хөдөө аж ахуйн хоршоологчдын үндэсний холбоо, НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газрын төлөөлөл, Хүнсний аюулгүй байдлын Үндэсний лавлагаа лаборатори, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, баталгаажуулалтын байгууллагаас Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнд хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлд зохистой дадлыг нэвтрүүлэх, аюулгүй байдлыг хангах

чиглэлээр ажилладаг тус бүр нэг этгээдийг эсхүл Үндэсний Зөвлөлийн гишүүний санал болгосноор үндсэн болон оролж ажиллах ажилтны нэрийг дэвшүүлнэ².

7.7. Үндэсний зөвлөлийн дарга нь хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын төсвийн шууд захирагч ба тэрээр техникийн болон баталгаажуулалтын хорооны гишүүн, нарийн бичгийн дарга нарыг томилж, чөлөөлнө.

7.8. Үндэсний зөвлөлийн ажиллах үндсэн хэлбэр нь хурал ба гишүүдийн 30-аас доошгүй хувьтай тэнцэх гишүүд биечлэн хуралд оролцсон тохиолдолд хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

7.9. Нарийн бичгийн даргын санал болгосны дагуу Үндэсний зөвлөлийн хуралд холбогдох салбарын техникийн шинжээчдийг урилгаар оролцуулж болно.

7.10. Үндэсний зөвлөлийн хурлыг зөвлөлийн дарга, түүний эзгүйд орлогч дарга даргална.

7.11. Үндэсний зөвлөлийн хурлын шийдвэр нь олонхийн саналд үндэслэнэ. Санал тэнцсэн тохиолдолд хурал даргалагчийн саналаар шийдвэр гаргана.

7.12. Үндэсний зөвлөлийн хурлын тэмдэглэлд хурал даргалагч болон нарийн бичгийн дарга гарын үсэг зурна.

7.13. Санхүүжилттэй холбоотой асуудлаар гарсан Үндэсний зөвлөлийн шийдвэр нь хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тушаалаар баталгаажсан байна.

7.14. Үндэсний зөвлөл нь орон тооны нарийн бичгийн дарга нар бүхий Техникийн болон Баталгаажуулалтын хороотой байна.

7.15. Үндэсний зөвлөл нь зохих журмын дагуу хийсэн албан бичгийн хэвлэмэл хуудас, тэмдэгтэй байна.

Найм. ХААЗД-ын Үндэсний Зөвлөлийн эрх үүрэг

Үндэсний зөвлөл нь дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

8.1. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэлд хөдөө аж ахуйн зохистой дадлыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар, стандарт, техникийн зохицуулалтыг үйл ажиллагааны төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршилтай уялдуулан эрүүл мэндийн асуудал эрхэлсэн болон Стандартчилал, техникийн зохицуулалтын асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж, батлах, хэрэгжилтэд хяналт тавих, шинэчлэх, өөрчлөх;

8.2. Техникийн болон баталгаажуулалтын хороодоос ирүүлсэн зөвлөмжийг хэлэлцэх, шийдвэр гаргах;

8.3. Хөдөө аж ахуй, хүнсний ногоо, жимс жимсгэнийн үйлдвэрлэлд чанарын менежментийг хэрэгжүүлэх, сайжруулах, салбар хоорондын уялдаа холбоог хангах, орон нутгийн нөхцөлд нийцүүлэх, ерөнхий удирдлагаар хангах

8.4. ХААЗД-ын баталгаажуулалтын ил тод байдлыг хангах, хүлээн зөвшөөрүүлэх зорилгоор олон нийтэд сурталчилах, мэдээлэх;

8.5. ISO 17011 стандартын шаардлагыг хангасан, Олон улсын итгэмжлэлийн байгууллагын харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээрт (ОУИБ-ын ХХЗГ)-д гарын үсэг зурж, нэгдсэн итгэмжлэлийн байгууллагад энэ зааврынзаасан мэргэжлийн байгууллагын чадавхыг үнэлүүлж, итгэмжлүүлэхээр санал хүргүүлэх,

8.6. Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн хуулийн 23 дугаар зүйлийн 23.1.2 дахь заасны дагуу ХААЗД-ыг баталгаажуулах чиглэлээр итгэмжлэлийн хүрээгээ тогтоолгосон, ISO / IEC 17065: 2012 стандартын шаардлагыг хангасан, төрийн, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагыг хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчийн ХААЗД-ын шаардлагад нийцсэн үйл ажиллагаа явуулж буй эсэхэд техникийн дэд хорооны чиглэл тус

² Үндэсний Зөвлөлийн бүрэлдэхүүнийг сонгохдоо аливаа нэг салбар, байгууллагын ашиг сонирхол давамгайлахаас зайлсхийж, ашиг сонирхлын тэнцвэрийг хангана.

бүрээр тохирлын үнэлгээ хийх, баталгаажуулах ажлыг гүйцэтгүүлэхээр томилох саналыг хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хүргүүлэх, шийдвэрлүүлэх

8.7. ХААЗД-ын заавар, стандарт, техникийн зохицуулалт нь зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж буй эсэхэд тогтмол хяналт тавьж, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль, тогтоомжийн хүрээнд тогтмол шинэчлэх

8.8. ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдсан болохыг илэрхийлсэн тэмдгийн загварыг батлах, Барааны тэмдэг, газар зүйн заалтын тухай хуулийн дагуу Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдэгдэл гаргаж, гэрчлэх тэмдгээр бүртгүүлэх, эзэмших, хяналт тавих

8.9. ХААЗД-ын баталгаажуулалтын гэрчлэх тэмдгийг зөв ашиглах, хэрэглэх нөхцлийг тодорхойлсон журмыг боловсруулж, батлан, мөрдөж ажиллах

8.10. ХАА-н салбарт зохистой дадлыг нэвтрүүлэх, хүнсний сүлжээний анхан шатанд бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах төрийн бодлого, тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны төлөвлөгөөний санал боловсруулах

8.11. Үндэсний зөвлөл, техникийн болон баталгаажуулалтын хорооны үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилтийг нийслэл болон аймаг орон нутагт үе шаттайгаар хянаж, гарсан үр дүн, оролцогч талуудаас гаргасан санал, хууль тогтоомжид орсон өөрчлөлтөд үндэслэн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагаа болон ХААЗД-ын Үндэсний хөтөлбөрийг шинэчлэх, сайжруулах санал боловсруулах

8.12. ХААЗД-ын баталгаажуулалтын үйл ажиллагаа, түүнчлэн ХААЗД-ын гэрчлэх тэмдгээр тэмдэглэгдсэн бүтээгдэхүүний чанарын талаарх гомдол, мэдээллийг ISO 10002 стандартад нийцүүлэн хүлээн авах, шийдвэрлэх, тэдгээрийг бүртгэж, баримтжуулах зорилгоор захиргааны гэрээг итгэмжлэлийн байгууллага, баталгаажуулалтын байгууллага, үйлдвэрлэл эрхлэгчтэй байгуулж, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах

8.13. Гомдол гаргах дарааллыг тодорхойлж, өргөдөл гомдлыг хэрхэн шийдвэрлэсэн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим хуудсанд байршуулан, олон нийтэд мэдээлэх

8.14. ХААЗД-ын эрх зүй, удирдлагын бүтэц, зохион байгуулалт, баталгаажуулалттай холбоотой баримт бичиг, мэдээллийг холбогдох төрийн болон төрийн бус байгууллагаас гаргуулан авах, мэдээллийн сан бүрдүүлэх, хяналт тавих, олон нийтэд хүргэх

8.15. Хүнс хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд хагас жил тутам ажлаа тайлагнах

Ес. ХААЗД-ын хорооны эрх үүрэг

9.1. Техникийн болон Баталгаажуулалтын хороо нь тус бүр 9 хүртэлх хүний бүрэлдэхүүнтэй байна.

9.2. Хорооны гишүүнд тухайн асуудлаар мэргэшсэн, сонирхлын зөрчилгүй шинжээч, зөвлөхийг томилно.

9.3. Хорооны гишүүн шинэ гишүүнийг сонгохоор Үндэсний Зөвлөлийн даргад санал хүргүүлж, шийдвэрлүүлж болно.

9.4. Хүнсний ногоо, жимс жимсгэнэ, буудайн төрлийн таримал, зөгийн аж ахуй, мал аж ахуйн дэд хороотой байж болох ба хөдөө аж ахуйн шинжлэх ухаан, тухайлбал, шавж судлаач, ургамлын өвчин, ургамал хамгаалал, агрономи, хөрсний үржил шим, хүнсний ногоо, жимс жимсгэнэ тариалах асуудлаар мэргэшсэн шинжээч, зөвлөхийг хорооны бүрэлдэхүүнд ажиллуулна.

9.5. Баталгаажуулалтын хороо нь итгэмжлэл, тохирлын үнэлгээний шинжээч, зөвлөх, ISO 17065 стандартын шаардлагыг хангасан, итгэмжлэгдсэн баталгаажуулалтын байгууллага, 17025 стандартын дагуу магадлан итгэмжлэгдсэн лабораторийн төлөөллөөс бүрдсэн байна.

9.6. Хорооны ажиллах үндсэн хэлбэр нь хурал ба улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

9.7. Хорооны гишүүдийн 30-аас доошгүй хувьтай тэнцэх гишүүд биечлэн хуралдаанд оролцсон тохиолдолд хурлын шийдвэрийг хүчин төгөлдөр гэж үзнэ.

9.8. Техникийн хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.8.1. Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэгт заасны дагуу хөдөө аж ахуйн анхан шатны үйлдвэрлэлийн төрөл, хүчин чадал, хамрах хүрээ, газар зүйн байршлаас хамаарч ХААЗД-ыг хялбаршуулан нэвтрүүлэх заавар, шаардлагатай стандарт, техникийн баримт бичгийг боловсруулах, бүрдүүлэх;

9.8.2. Шаардлагатай тохиолдолд заалтыг тайлбарлах, нэг мөр ойлголтыг бий болгох;

9.8.3. Баталгаажуулалтын шалгуур үзүүлэлтийг тодорхойлох болон холбогдох бусад асуудлыг шийдвэрлэх.

9.9. Баталгаажуулалтын хороо нь дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

9.9.1. баталгаажуулах үйл ажиллагааг шаардлагын дагуу төлөвлөх, хэрэгжүүлэх, шинэчлэх;

9.9.2. баталгаажуулалтын байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох, шинэчлэх, сайжруулах;

9.9.3. баталгаажуулалтын байгууллагатай захиргааны гэрээ байгуулах, хянах, дүгнэх, үр дүнг магадлах,

9.9.4. Тохирлын үнэлгээ, баталгаажуулалтыг нэг ижил түвшинд явуулах, нэгдмэл байдлыг хангах нөхцлийг бүрдүүлэх

9.9.5. үйлдвэрлэгчид баталгаажуулалтад хамрагдахад нь туслах зорилгоор гарын авлага, бусад баримт бичгийг боловсруулах;

9.9.6. баталгаажуулалттай холбоотой аливаа асуудлыг шийдвэрлэх

9.9.7. ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдсан болохыг илэрхийлсэн тэмдгийн загварыг гаргах;

Арав. ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдсан болохыг гэрчлэх тэмдэг

10.1. Хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүний анхан шатны үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаа нь ХААЗД-ын шаардлагад нийцсэнийг эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаас баталгаажуулсан тохиолдолд үйлдвэрлэгч буюу үйлдвэрлэгчдийн бүлэг ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдсан болохыг гэрчлэх тэмдгийг ашиглана.

10.2. Үндэсний Зөвлөл эрх бүхий баталгаажуулалтын байгууллагаар дамжуулан баталгаажуулалтын тэмдэг ашиглах зөвшөөрлийг үйлдвэрлэгч буюу үйлдвэрлэгчдийн бүлэгт олгоно.

10.3. Үндэсний зөвлөлийн Баталгаажуулалтын хороо, Эрх бүхий баталгаажуулалтын байгууллага, баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдсан болохыг гэрчлэх тэмдгийг ашиглах тухай гурван талт захиргааны гэрээ байгуулж, хэрэгжилтийг хангаж ажиллана.

10.4. Үндэсний Зөвлөл нь ХААЗД-ын баталгаажуулалтад хамрагдсан болохыг гэрчлэх тэмдэг, мэдэгдэл, гэрчилгээний ашиглалтын талаар үйлдвэрлэгч / үйлдвэрлэгчийн бүлэгт хяналт шалгалт хийж, үр дүнг нягтлан, зөрчлийг арилгах арга хэмжээг авч хэрэгжүүлэх чиглэл өгнө.

10.5. Энэ зааврын 1.1 дэх хэсэгт заасан гэрчлэх тэмдэг нь тухайн цувралын бүтээгдэхүүн баталгаатай гэсэн утгыг агуулахгүй бөгөөд хүнсний бүтээгдэхүүний сав баглаа боодлын шошгод байршуулахгүй.

10.6. Баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч нь ББ-ын гэрчилгээ, гэрчлэх тэмдгийг сурталчилгааны материал, товхимол, зурагт хуудас, бусад ижил төстэй хэвлэмэл материал, хэвлэл мэдээллийн хэрэгсэлд ашиглаж болно.

10.7. Бүтээгдэхүүний шошгод зөвхөн ХААЗД-ыг нэвтрүүлж, баталгаажуулсан фермерийн аж ахуйд үйлдвэрлэснийг илтгэх мэдэгдэл тавьж болно.

10.8. Баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч нь баталгаажуулалтын тэмдгийн талаархи аливаа хуурамч, төөрөгдүүлсэн мэдээлэл өгч болохгүй.

10.9. Энэ зааврын 1.1 дэх хэсэгт заасан гэрчлэх тэмдгийг зөвхөн баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгчийн үйл ажиллагаа ба таримлын төрөлд ашиглах ба нэг өмчлөгчтэй боловч баталгаажуулалтад хамрагдаагүй таримал, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлд хамаатай мэтээр ойлголт өгөх ёсгүй.

10.10. Баталгаажуулах тэмдгийг зураг хэлбэрээр хуулбарлах эсхүл томсгон ашиглаж болно.

10.11. Баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч нь баталгаажуулалтын тэмдгийг эзэмшигчийн нэр хүндийг гутаах аливаа үйлдэл гаргаж болохгүй.

10.12. Баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч нь гэрчилгээг түдгэлзүүлсэн буюу цуцалсан тохиолдолд баталгаажуулалтын тэмдгийг аливаа хэлбэрээр ашиглах, баталгаажуулалтын талаар аливаа заалтыг агуулсан сурталчилгааны материалыг ашиглахаа зогсооно.

10.13. Гэрчлэх тэмдэг, мэдэгдэл, гэрчилгээг ашиглахтай холбоотой зөрчлийн цар хүрээнээс хамааран зөвлөгөө өгөх, сануулах, давтан зөрчлийн үед гэрчилгээ олгохоос татгалзах хүртэл арга хэмжээг авч болно.

10.14. Баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч нь баталгаажуулалтын тэмдгийг буруу ашигласан үйлдлээ зогсоох арга хэмжээ аваагүй тохиолдолд ББ нь баталгаажуулалтыг цуцална.

10.15. Үндэсний Зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл баталгаажуулалтын байгууллагад баталгаажуулалтын тэмдгийг буруу ашигласан үйлдлийг таслан зогсоох арга хэмжээ авах чиглэл өгөх эсхүл өөрөө хуульд нийцсэн шаардлагатай арга хэмжээг авна.

10.16. Баталгаажуулалтад хамрагдсан үйлдвэрлэгч нь Үндэсний Зөвлөлөөс тогтоосон тарифын дагуу баталгаажуулалтын гэрчлэх тэмдэг ашигласны төлбөрийг баталгаажуулалтын байгууллагаар дамжуулан төлнө.